

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2014 он. 1 сар. №01 (059)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

Шилдэг сэтгүүл, шинэ үнэлэмж

Ил уурхайгаас далд уурхайд

## НОЙРНООСОО СЭРЭХ ЖИЛ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

8165800016794761



# Canon

Delighting You Always



## imageRUNNER iR2520

### НЭГ ХУУДАС ХЭВЛЭХ ӨРТӨГ: 7.8₮

Хэвлэнэ /сүлжээгээр/  
Хувилана  
Сканнердана /сүлжээгээр/  
Факс /нэмэлтээр суурилуулна/

### ҮЗҮҮЛЭЛТ:

Хэвлэх хурд: 20 ppm  
Санах ой: 512 MB  
Нягтаршил: 600x600 dpi  
Цаасны багтаамж: 250х  
Цаасны хэмжээ: А3, А4, А5, В5

₮2'662'000  
/НӨАТ 10% орсон болно/



## АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ ХАМГИЙН ХЯМД ХУВИЛАГЧ

### СҮЛЖЭЭНИЙ ОРЧИНД ХЭВЛЭХ

Стандарт сүлжээний функцийг тусламжтай олон хэрэглэгч нэгэн зэрэг хэвлэхээс гадна, хувилагчийн хэрэглээнд хяналт тавих, хэрэглэгчийн эрхийг хязгаарлах гэх мэт төхөөрөмж дээр хийгддэг үйлдлүүдийг компьютер дээрээс хийх боломжтой.

### АР ӨВӨРГҮЙ ХЭВЛЭХ - ЗАРДЛЫН ХЭМНЭЛТ

Ар өвөргүй хэвлэдэг стандарт горимтой болсноор цаасны хэрэглээ 50% бууруулж байгууллагын зардлаа хэмнэх боломжийг олгоод зогсохгүй, та биднийг байгаль дэлхийгээ хайрлах эко хэрэглээнд хөтлөх болно.



ЗАРДЛЫН ХЯНАЛТ



БҮТЭЭМЖИЙН ӨСӨЛТ



МЭДЭЭЛЛИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ



БАТАЛГААТ  
ХУГАЦАА

### КАНОН ХУВИЛАГЧИЙН БОРЛУУЛАЛТЫН ДАРААХ ГЭРЭЭТ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улирал бүрийн тогтмол үзлэг, оношлогоо
- Гэмтэл учирсан тохиолдолд газар дээр нь шуурхай очиж үйлчилнэ
- Шаардлагатай сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, засварлах
- Хор, булыг захиалж, солих

АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТЕР ITZONE КОМПАНИ

Хаяг: Компьютер ландин урд Канон төв

Цагийн хуваарь: Даваа-Ням 10:00 – 19:00 цаг, Утас: 70110544, 77312424

Вэб: www.itzone.mn, store.itzone.mn, www.facebook.com/ITZoneStore



# 1сек 35.000-50.000₮

# Реклам сурталчилгаа

# ТВ ШТОРК

мэргэжлийн түвшинд хийж байна.



Манай байгууллага нь  
И-МЭЙЛ маркетингийн  
ЦОГЦ  
үйлчилгээг танд  
санал болгож байна.



Web site  
Mobile web  
Mobile application

Бид таны болон танай байгууллагыг бүрэн илэрхийлэх  
вэб, мобайлвэб, мобайл аппликашиныг  
Мэргэжлийн өндөр түвшинд хурдан шуурхай хийж үйлчилнэ.

Харилцах утас: 9111-6586, 9111-6588

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

Б.Цогзаяабаатар /9919-0715/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Х.Хулан

Б.Үүрийнтуяа

Б.Бямбадорж

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР: Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /9409-2904/

Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох /9409-2906/

## “ЕСОНОМУ” ТВ СТУДИ

РЕДАКТОР: Ж.Баяржаргал

ЗУРАГЛААЧ: Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ: Т.Баярсайхан

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,  
Их сургуулийн гудамж. АВ center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762  
www.mongolianeconomy.mn  
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

### БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар

“Max mall” салбарууд

## ОНЛАЙН ЗАХИАЛГЫГ

<http://mongolianeconomy.imedia.mn/>

“Монгол Улсын  
2013 оны  
Шилдэг сэтгүүрт”

АГУУЛГА

БИЗНЕС & САНХҮҮ

- 8 Нойрноосоо сэрэх жил
- 13 Хүлээхийн учир
- 15 Шилдэг сэтгүүл, шинэ үнэлэмж
- 16 Зохицуулалттай хүнсний үйлдвэрлэл
- 18 Гэрээг амжилттай байгуулахад юуг анхаарах вэ?

ЭДИЙН ЗАСАГ

- 20 2014 оны Монголын эдийн засгийн хэтийн төлөв
- 24 Яагаад улаан буудай импортлоход хүрэв
- 26 Үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөл
- 28 Төгрөгийн сулралын цаад учир
- 30 Зөөврийн компьютерийг хэрхэн сонгох вэ

УУЛ УУРХАЙ

- 32 Алтны салбарт аргамжаа хэрэгтэй юу?
- 34 С.Оюун сайд дэлхийд данслагдав
- 36 Ил уурхайгаас далд уурхайд
- 38 Ногоон соёл иргэншил



“MONGOLIAN ECONOMY”  
СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

**Б.БЯМБАСАЙХАН**

Монголын бизнесийн зөвлөлийн  
ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy”  
сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

**Б.БОЛД**

“Рио Тинто” компанийн Зэсийн  
груплын Олон улсын үйл ажиллагааг  
эрхэлсэн Ерөнхийлөгч

**С.БЭХБАТ**

ЭЗХЯ-ны Инноваци, тер. хувийн  
хэвшлийн түншлэлийн газрын дарга

**Д.ЖАРГАЛСАЙХАН**

МНН груплын ерөнхийлөгч

**Ц.БАТСҮХ**

СЭЗДС-ийн  
Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

**Ж.СҮНЖИДМАА**

“Тийбоди Энержи” компанийн Монгол дахь  
хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал  
хариуцсан менежер

**Б.ТҮВШИНТӨГС**

Эдийн засгийн судалгаа,  
эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

## МОНГОЛ:

## ДНБ

Дотоодын нийт бүтээгдэхүүн 17 их наяд төгрөг (10.27 тэрбум ам.доллар) байв. Ам.долларын дундаж ханш 1680 төгрөгтэй харьцаж байсан. Тэгвэл энэ онд ам.доллар 2000 төгрөгтэй харьцана гэж үзэж зарим шинжээч үзэж байна. Тэднийхээр Монгол Улсын ДНБ 10 тэрбумаас 11 тэрбум ам.доллар орчимд эргэх төлөвтэй. Харин ЭЗХЯ-ны мэргэжилтнүүдийн тооцоогоор 2014 онд ДНБ 14.8 хувиар өсч, нэрлэсэн дүнгээр 20.4 их наяд төгрөгт хүрэх хандлагатай байгаа. Мөн энэ хэмжээ 2015-2016 онд 15-16 орчим хувиар өсөх төлөвтэй аж.

## Ипотек



Ипотекийн зээлийг

анх төлөвлөж байснаар хоёрдагч зах зээлд гаргаж чадсан. Монголын ипотекийн корпораци “МИК Актив-1” ХХК-ийг байгуулж арилжааны банкуудтай гэрээ хийсэн. Ийнхүү ипотекийн зээлийг тасралтгүй үргэлжлүүлэхээр өнгөрсөн оны сүүлчээр үнэт цаас гаргасан. Одоогоор “Голомт”, “Худалдаа хөгжлийн”, “Хаан”, “Хас”, “Улаанбаатар”, “Эрэл” зэрэг арилжааны есөн банктэй гэрээтэй байна. Дээрх банкуудаас найман хувийн хүүтэй нийт 322.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн багцыг худалдан авчээ. Ямартай ч МИК-аас 322.9 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаснаар 2014 онд 7200 өрхөд шинээр зээл олгох боломж бүрджээ.

## Чингис бонд

Чингис бондын хөрөнгө оруулалт ерөнхийдөө дуусч байна. Нийт 1.5 тэрбум ам.доллараас 360 орчим тэрбум төгрөг



үлдсэн. Энэ мөнгийг бүгдийг нь үйлдвэржилтэд зарцуулахаар болсон гэдгийг Ерөнхий сайд мэдэгдээд байгаа. 2014 онд иргэдийн дунд нээлттэй төслийн уралдаан зарлаж олгохоор болсон. Чингис бондын хөрөнгөөс “Боинг” компаниас “Боинг 767-300 ER” онгоцыг худалдан авахад 114 сая ам.долларыг, “Гудамж” төслийн хүрээнд 200 сая ам.доллар зарцуулсан. Мөн ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд 45 сая ам.доллар, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 13.5 сая ам.долларыг тус тус зарцуулахаар болсон. Анхны төлөвлөгөөгөөр бондын мөнгөөр нийт арван долоон төслийг санхүүжүүлэхээр тусгасан байгаа.

## Зээлжих зэрэглэл

Олон улсын “Fitch” агентлагийн үнэлгээгээр Монгол Улсын зээлжих зэрэглэл буурчээ. Тус агентлаг Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг “B+” гэж үнэлсэн. Мөн цаашдын төлөвийг тогтвортойгоос сөрөг ангилалд оруулжээ. Харин богино хугацааны зээлжих зэрэглэл нь “B” байгаа юм. “Fitch” агентлаг зэрэглэл бууруулахдаа хэд хэдэн хүчин зүйлийг тооцоолсон байна. Тухайлбал, Монгол Улсын төсвийн алдагдал, төсвийн гадуурх хөрөнгө оруулалт ДНБ-ий 12 хувьд хүрч байгаа нь Төсвийн тогтвортой байдлын хуулийг зөрчиж байна. Мөн 2013 оны эхний арван сарын байдлаар зээл олголтын хэмжээ 53 хувь, инфляци хоёр оронтой тоонд орсон нь зээлжих зэрэглэл буурахад нөлөөлжээ. Манай Засгийн газрын нийт өрийг 2014 оны эхэнд ДНБ-ий 50 хувьд хүрэхээр байгааг тус агентлаг онцолжээ.

## Татвар

Татварын ерөнхий газраас энэ онд улсын төсөв, хүний хөгжил сангийн төсөв, орон нутгийн төсөвт нийтдээ 3,334.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр байгаа. Энэ нь нэгдсэн төсвийн нийт орлогын 48.4 хувь нь юм. Мөн Гаалийн ерөнхий газраас улсын төсөвт 1,919.9 тэрбум төгрөг төвлөрүүлэх юм. Энэ нь нэгдсэн төсвийн орлогын 27.8 хувийг эзэлж байна. Татварын болон Гаалийн ерөнхий газар нь 2014 онд нэгдсэн төсвийн нийт орлогын 76.2 хувийг буюу 5,254.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Татварын ачааллын хэмжээ сүүлийн 10 жилийн дунджаар 28.0 хувь байсан. Тэгвэл энэ онд 30.4 хувьд хүрэхээр байна.

Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын орлого (тэрбум төгрөгөөр)

	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Нийт орлого	2,170.5	1,972.6	3,078.3	4,468.2	4,975.8	7,257.9	6,894.8
Татварын ерөнхий газар	1,166.0	938.8	1,945.6	2,159.5	2,335.4	3,163.6	3,334.1
Гаалийн ерөнхий газар	588.6	514.9	877.6	1,421.0	1,444.3	2,331.7	1,919.9

**ДЭЛХИЙ ДАХИНД:**

**АНУ**




АНУ-ын хувьцаанууд өнгөрсөн арванхоёрдугаар сарын сүүлээр маш өндөр өсөлттэй гарчээ. Үүний шалтгаан нь тус улсын эдийн засаг тооцоолсноос өндөр өсөлттэй байсантай холбоотой аж. Өнгөрсөн онд Dow Jones, S&P индексүүд тус тус 20-иос дээш, Nasdaq индекс 30-аас дээш хувиар өссөн байна.

**БНХАУ**

БНХАУ-ын эдийн засаг өнгөрсөн онд 7.6 хувиар өссөн гэх. “Синхуа” агентлаг Засгийн газрын гишүүдтэй уулзсаны дараа уг таамгийг дэвшүүлжээ. Энэ нь тус улсын Засгийн газрын таамаг (7.5 хувь)-аас ялимгүй өндөр үзүүлэлт аж. Харин 2012 онд эдийн засаг нь 7.7 хувийн өсөлттэй байв. Дээрх таамаг шинжээчдийнхтэй яв цав нийцэж буй. Гэвч өнгөрсөн оны өсөлт 1997-1998 оны Азийн хямралаас хойшхи хамгийн тааруухан өсөлтөд тооцогдов.

**ОХУ**



ОХУ-ын ашиг, орлого муутай компаниудын тоо өнгөрсөн оны эхний арван сарын байдлаар 2.4 хувиар нэмэгдэж, 29.4 хувьд хүрчээ. Энэ талаар “Росстат” статистикийн агентлаг мэдээлэв. Ялангуяа уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын 36.7 хувь ашиг муутай ажиллажээ. Энэ тоо 2012 онд 30.5 хувьтай байв.

**Украин**

Украин өнгөрсөн оны арваннэгдүгээр сард Европын холбоотой улс төрийн холбоо сүлбээ тогтоож, чөлөөт худалдаа хийх гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурахаас



татгалзсан. Ийнхүү гадаад бодлогодоо эргэж буцсан шийдвэр гаргасныхаа дараа Засгийн газар нь бонд гаргажээ. ОХУ энэ оны эхээр 15 тэрбум ам.долларын тусламж үзүүлж, уг бондыг худалдан авахаар тохиролцсон байна. Эхний хэсэг болох гурван тэрбум ам.долларыг хүлээн авсан талаар Украины Ерөнхий сайд Микола Азаров өнгөрсөн арванхоёрдугаар сарын 25-нд мэдэгджээ.

**Франц**

Францын статистикийн агентлаг INSEE нь улсынхаа эдийн засгийг өнгөрсөн оны эцсийн улиралд 0.4 хувийн өсөлттэй байсан болов уу гэсэн таамаг дэвшүүлж байна. Харин гуравдугаар улиралд өсөлт 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байв. Өнгөрсөн онд тус улсын эдийн засаг ерөнхийдөө 0.2 хувийн өсөлттэй байсан



бололтой. Харин евро бүсийн бусад орны хувьд эдийн засаг нь харьцангуй сэргэх төлөвтэй байв.

**Их Британи**

Өнгөрсөн онд Их Британид орон сууц борлуулалтын хэмжээ 24 хувиар өсчээ. Энэ талаар HMRC татварын байгууллага мэдээлэв. Мөн оны арваннэгдүгээр сарын байдлаар тус улсад 96 г мянган орон сууц борлуулагдсан байна. Энэ нь 2009 сүүлээс хойшхи хамгийн сайн үзүүлэлт ажээ. Үүний зэрэгцээ ипотекийн зээл шинээр хүсэгчдийн тоо 39 хувиар өссөн болохыг Британийн банкны холбоо мэдэгдсэн байна.




## ОНЦЛОХ

# НОЙРНООСОО СЭРЭХ ЖИЛ

## Э.ЗОРИГТ

## Тоон тойм

Муу нэрнээс салдаггүй Монголын хөрөнгийн зах зээл өнгөрсөн онд улам л уруудсан үзүүлэлттэй байлаа. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурсан. Тор 20 индекс ч огцом унасан үзүүлэлттэй байна. /Дэлгэрэнгүйг графикаас харна уу/ Товчхондоо Хөрөнгийн зах зээлийн хувьд 2013 онд уналттай байлаа.



## Багцийн арилжааны дэлгэрэнгүй (2013 оны эхний хагас жил)

Үнэт цаасны нэр	Сарилжсан ширхэг	Нэгж үнэ	Нийт үнийн дүн	Арилжсан огноо
1 Монинжбар	5,150,000	301	1,550,150,000	2013.01.16
2 Дархан нэхий	165,000	7,900	1,303,500,000	2013.01.16
3 Говь	203,857	4,750	968,320,750	2013.02.07
4 Монголиа Девелопмент Ресорсис	672,177	900	604,959,300	2013.03.29
5 Хай Би Ойл	2,611,979	175	457,096,325	2013.04.09
6 Дорнод худалдаа	12,195	8,000	97,560,000	2013.05.02
7 Шимтлэг	26,672	78	2,080,416	2013.06.07
8 Баян алдар	143,820	357	51,343,740	2013.06.12
Нийт			5,035,010,531	

Эх сурвалж: СЗХ

Өнгөрсөн оны зургаадугаар сарын 28-ны байдлаар нийт 125 удаагийн арилжаагаар 122 компанийн 21.9 сая ширхэг хувьцааг 12.3 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хувьцааны арилжааны үнийн дүн 48.6 тэрбум төгрөгөөр буюу 79.80 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үнэт цаасны нэр	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2012 оны эхний хагас жил	2013 оны эхний хагас жил	Үнийн дүнгээр	Хувиар
Засгийн газрын бонд	-	-	-	-
Хувьцаа /тэрбум төгрөг/	60.9	12.3	-48.6	-79.80%
Компанийн бонд	-	-	-	-

Эх сурвалж: СЗХ


## Брокер диллерийн компаниуд

1	BDSC	БиДиСек ХК	28,277,959	12,168,984,502
2	DELG	Дэлгэрхангай секьюритиз ХХК	488,751	2,753,372,949
3	ECM	Евразиа капитал монголиа ХХК	4,457,584	2,094,819,049
4	RESC	Рескап секьюритиз ХХК	1,545,569	1,857,821,616
5	APS	Азиа Пасифик секьюритиз ХХК	418,627	499,428,890
6	GAUL	Гаули ХХК	1,707,442	472,745,179
7	STIN	Стандарт инвестмент ХХК	865,903	382,647,710
8	ZRGD	Зэргэд ХХК	246,052	324,828,744
9	MSEC	Монсек ХХК	208,532	316,378,738
10	BUMB	Бумбат-Алтай ХХК	207,723	315,417,824
11	BULG	Булган брокер ХХК	192,852	296,898,651
12	MERG	Мэргэн санаа ХХК	34,477	287,866,393
13	MNET	Монет ХХК	1,365,545	269,225,518
14	ARD	Ард капитал групп ХХК	279,231	246,387,618
15	DRBR	Дархан брокер ХХК	464,806	232,554,831

Эх сурвалж: СЗХ

Тайлант хугацааны эцсийн байдлаар нийт 83 брокер диллерийн компани бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 53 нь арилжаанд оролцож гүйлгээ хийсэн байна. Үнэт цаасны гүйлгээгээр “Би Ди Сек”, “Дэлгэрхангай” секьюритиз, “Евроазиа капитал монголиа”, “Рескап” секьюритиз, “Азиа пасифик” секьюритиз зэрэг компани тэргүүлсэн байна. ▶

Хувьцааны арилжааны үнийн дүн (өмнөх оны мөн үетэй харьцуулав)



## Шинэчлэлийн салхи

Хөрөнгийн биржийн арилжаа унаж, зах зээл хумигдсан гээд ихэнх үзүүлэлтүүд нь уналттай байсан хэдий ч хууль эрх зүйн орчин сайжирсан нь үнэт цаасны зах зээлд шинэчлэлийн салхи үлээсэн. МХБ-ийн дэд захирал Г.Саруул “Өнгөрсөн онд хөрөнгийн зах зээлийн гол хуулиудыг шинэчилж бас шинээр баталлаа. Нэгдүгээр сарын 1-нээс хууль хэрэгжээд ирэхээр институциональ хөрөнгө оруулагчдыг татах боломж бүрдэнэ. Кастодиан банкны үйлчилгээг ирэх оны эцсээр жигдрэх болов уу. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд таатай болно. Ямартай ч өнгөрсөн онд бид хөрөнгийн зах зээлийн гол хууль эрх зүйн тогтвортой орчныг бий болгож чадлаа. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон бусад үзүүлэлт сайжирна” гэсэн юм. Хөрөнгийн зах зээлийн хөрс болсон “Үнэт цаасны зах зээлийг зохицуулах тухай хууль”-ийг шинэчлэн баталсан нь хэд хэдэн давуу талыг бий болгосон аж. Мэргэжлийн хөрөнгө оруулагч буюу байгууллагын хөрөнгө оруулалтын сан болох тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан /нээлттэй, хаалттай/, даатгалын сан, хөрөнгө оруулалтын банк үнэт цаасны зах зээлд оролцох боломжийг тус хуулиар нээсэн. Энэ бол маш том дэвшил. Алга ташилт дагуулсан томоохон үйл явдал байлаа. Түүнчлэн Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа гаднын болон дотоодын хөрөнгө оруулагчид олон улсын хөрөнгийн биржид нээлттэй компани хэлбэрээр хөрөнгө босгосон хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид арилжаалах бололцоо нь нээгдсэн. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын биржид бүртгэлтэй 40 гаруй компанийн олон улсын зах зээл дээрх үнэлгээ нь ойролцоогоор 18 их наяд төгрөгтэй дүйцэхээр байна. Гэтэл манай хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ дөнгөж 1.7 их наяд төгрөг

байх жишээтэй. Шинэ хуулиар эдгээр 40 гаруй компани Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа шууд арилжаалах боломжтой. Тэднийг татсанаар өндөр өгөөжтэй хувьцааг өөрийн орны хөрөнгийн биржээс шууд авах, хөрөнгө оруулах боломжийг олгож байгаа юм. Ингэж чадвал манай хөрөнгийн биржийн үнэлгээ өснө.

Монголын санхүүгийн зах зээлд банк давамгайлсан нь үндэсний үйлдвэрлэгч компаниудын өсөлтийг дэмжиж чадахгүй байна гэдэг. Өөрөөр хэлбэл банкны зээл томоохон хөрөнгө оруулалтад “жулддаг” нь нууц биш. Тэгвэл өнгөрсөн онд батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”-иар компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийдэг сангууд Монголын үнэт цаасны зах зээлд орж ирэх боломжийг нээж өглөө. Хөрвөх чадвартай зах зээл л хөгждөг. Хөрөнгийн зах зээл ч ялгаагүй энэ л жамаар хөгжих учиртай. Гэтэл Монголын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар муу байна. “Мандал генерал даатгал” компанийн Хөрөнгө оруулалтын шинжээч, диллер Г.Мөнх-Эрдэнэ “Би өнөөдөр авсан хувьцаагаа маргааш нь алдагдалгүй зарж чадаж байвал тэр хөрвөх чадвар бүхий зах зээл гэсэн үг. Гэтэл 1000 төгрөгөөр авсан хувьцааг маргааш нь зарах гэхээр 900-800 төгрөгөөр буюу алдагдалтай зарах болчихдог. Энэ нь манай хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар муу байгаагийн нотолгоо. Хөрвөх чадвар муу, хөгжих боломж сул байгаагийн гол шалтгаан нь Монголд өнгөрсөн оныг хүртэл хөрөнгө оруулагчдаа хамгаалсан, мэдээллийн ил тод байдлыг хангасан хууль эрх зүйн орчин байхгүй байсангай холбоотой” гэв. Тэгвэл энэ оноос хуулийн дагуу мэдээлэл нь ил тод болоод ирэхээр хөрөнгийн зах зээлд тоглогчид олшрох учиртай. Түүнчлэн үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар сайжирдаг жамтай. Хөрвөх чадвар сайжрахын хэрээр олон хүнийг хөрөнгийн зах зээлд татан оруулна. Ийм харилцан хамаарлын дүнд энэ зах зээл илүү хөгжинө гэх. Олон улсын жишгээс харахад хөрөнгийн зах зээлийн арилжааны бүтцийн 70 орчим хувийг хөрөнгө оруулалтын сангууд бүрдүүлдэг. Тухайлбал, хамтын, даатгалын, байгууллагын, улсын гээд. Гэтэл бид өнгөрсөн онд л энэ төрлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох хууль эрх зүйн орчинтой боллоо. Тиймээс өнөөдрийг хүртэл Монголын хөрөнгийн бирж “унтаа” гэх нэрнээс салаагүй. Харин одоо бол 100 төгрөгийн 70-ыг нь бүрдүүлдэг хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлд оролцох боломж бүрдсэн.

## Хүлээгдэж буй эрсдэл

Хөрөнгийн зах зээлийг хөрвөдөг, хөрөнгө мөнгө эргэлддэг болгохын тулд батласан хууль механизмынхаа дагуу хэрэгжих учиртай. Сайн хууль гарлаа гээд хэрэгжихгүй бол ямар ч ашиггүй. Хөрөнгийн зах зээл хөгжих олон “гоё мөрөөдөл” салхинд хийсч одно. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тус зах зээлийн мэргэжлийн оролцогчдын мэдлэг боловсрол, хуулийн хүрээнд ажиллах чадах уу гэх асуудал хөндөгдөж байна. Одоогоор Хөрөнгийн биржил бүртгэлтэй 80 гаруй боркер, диллерийн компани бий. Гэтэл эдгээрийн гуравны нэг нь л идэвхтэй ▶



► үйл ажиллагаа явуулж байна. Идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хэдээс нь зах зээлийн судалгаа хийдэг, түүнийгээ хувьцаа эзэмшигчиддээ мэдээлдэг боркер, дилерийн компани ховорхон гэдгийг мэргэжилтнүүд хэлж байгаа. Гэхдээ Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны гаргасан шийдвэрээр брокер, дилерийн компанийн эрхийг авахын тулд 500 сая төгрөгийн, Андеррайтерын компанийн эрх авахын тулд нэг тэрбум төгрөгийн, Хэрвээ хөрөнгө оруулалтын зөвлөхийн эрхээ цуг авах бол 1.6 тэрбумын хөрөнгийн босгыг давах ёстой болсон. “Тэнгэр капитал” ХХК-ийн дэд захирал Б.Дөлгөөн “СЗХ-ны гаргасан уг шалгуур зөв үү гэвэл зөв. Ийм босго тавьсан нь тухайн компанийн үнэлэмж, мэргэжилтнүүдийн чадварыг сайжруулах гол хөшүүрэг болох нь дамжиггүй. Тоо биш чанарт тулгуурласан зах зээл бий болно. Гэхдээ ирэх долоодугаар сарын 1-н гэхэд компаниуд энэ шаардлагыг хангаж чадах уу гэдэг эргэлзээтэй. Хэрвээ жил гаруйн хугацаа өгсөн бол компаниуд хөрөнгө оруулалтаа татаад, үйл ажиллагаагаа сайжруулаад энэ шалгуурт тэнцэж болох байсан байх. Гэтэл хугацаа нь хэтэрхий бага байна” гэв. /Брокер, дилерийн компанийн хөрөнгийн хэмжээг хүснэгтээс харна уу/

Үнэт цаасны зах зээлийн мэргэжилтнүүдэд тавигдаж байгаа өөр нэг шалгуур бол ёс зүй, зах зээлийн мэдрэмж юм. Олон улсад бол мэргэшсэн санхүүгийн, эрсдэлийн шинжээчийн гээд маш олон төрлийн шалгалт байдаг. Энэ шалгалтыг өгсөн хүнд гаднын аль ч хөрөнгө оруулагч итгэдэг. Тухайн брокер, дилерийг өндөр мэдлэг, ёс зүйтэй, зах зээлийн мэдрэмжтэй гэж үнэлдэг. Гэтэл манайд ийм үнэлэмж, боловсролын систем байдаггүй гэдгийг

салбарынхан хэлж байна. Г.Мөнх-Эрдэнэ “Өнөөдрийн Монголын эдийн засгийн ухааны их, дээд сургуулиудад энэ талаар А үсэг ч заадаггүй. Тийм болохоор одоо байгаа мэргэжилтнүүд ёс зүйн талаар тийм ч сайн мэдлэгтэй биш. Тиймээс энэ талын ойлголт өгдөг, баталгаажуулдаг институци хэрэгтэй байна. Ийм институцитай болчихвол брокер, дилерүүд ёс зүйн ойлголттой болж хууль дүрмийнхээ дагуу ажиллаж эхэлнэ. Хууль дүрмийнхээ дагуу ажиллаад ирэхээр хөрөнгө оруулагчдын итгэл сайжирч, хөрөнгийн зах зээл хөгжинэ” гэсэн юм. Ямартай ч энэ тал дээр эхнээсээ арга хэмжээ авч эхэлсэн тул бага багаар эерэг үр дүн гарах байх гэж найдаж болох.

## Өдөөгчгүй зах зээл

Яг одоогийн байдлаар хөрөнгийн зах зээл тойрсон хүлээлт их. Нэг талаас нөгөө IPO гаргах компаниуд нь хөрөнгө оруулагчид байгаа болов уу гэх хүлээлттэй. Нөгөө талдаа хөрөнгө оруулагчид нь чанартай IPO байна уу гээд сууж байна. Тиймээс тэднийг сэрээхийн тулд зарим нэг алхмыг хийх хэрэгтэй гэдгийг хэлэх хүн цөөнгүй. Нэг талаас хөрөнгийн бирж дээр хөрөнгийн урсгал бий болгох хэрэгтэй. Үүний тулд СЗХ-ноос Даатгалын компанийн нөөц хөрөнгийн 10 хүртэлх хувийг А самбар дээр байгаа хувьцаанд хөрөнгө оруулах журмыг батлахаар байгаа. СЗХ-ны мэдээлж байгаагаар ямартай ч шийд бол гарсан. Удахгүй журам батлагдана гэсэн. Үүнтэй холбоотой энэ онд зөвхөн даатгалын компаниудаас гэхэд хөрөнгийн зах зээлд дөрвөн тэрбум төгрөг орж ирэх боломжтой байгаа аж. МХБ-ийн дэд захирал Г.Саруул “Одоо зах зээлийн ►


эргэлт бага байгаа ч ойрын ирээдүйд 20-30 дахин өсөх боломжтой гэж харж байна. Энэ онд 2-3 шинэ хувьцаа гарах болов уу. Мөн энэ оны эхний хоёрдугаар хагасаас өмнө Засгийн газрын бондын арилжааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах тал дээр Сангийн яамтай ойлголцсон. Тэгэхээр өрийн зах зээл идэвхжинэ гэж харж байна” гэжээ. Хуультай холбоотой хөрөнгө оруулалтын сангууд ч удахгүй бий болно. Энэ онд ойролцоогоор 1-2 хөрөнгө оруулалтын сан бий болох болов уу гэдэг хүлээлт байгаа аж.

Даатгалын болон бусад хөрөнгө оруулах сонирхолтой компаниуд хувьцаа авах гэхээр шаардлага хангах тийм хувьцаа байна уу гэвэл эргэлзээтэй. Энэ эргэлзээг тайлж талуудын хүсэл сонирхлыг өдөөж өгөхгүй бол хөрөнгийн зах “унтаа” нэрнээсээ салахгүй ч байж мэднэ. Үүн дээр л андеррайтерын компаниуд сайн ажиллах хэрэгтэй байна. Мэргэжилтнүүдийн төсөөллөөр бол энэ онд 3-4 IPO гарахаар байгаа. Гэхдээ хэр чанартай, ямар хэмжээний байх нь одоогоор тодорхойгүй. Тиймээс андеррайтерууд чанартай IPO эрэлд эртхэн мордохгүй бол хөрөнгийн зах зээлийн хүлээлтийн байдал удаан үргэлжилж магад. Мөн сайн IPO олох нэг боломж байгаа аж. Тэр нь жижиг, дунд үйлдвэрлэл /ЖДҮ/. Г.Мөнх-Эрдэнэ “ЖДҮ”-г дэмжих Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, хөрөнгө оруулалтын сан, андеррайтерын компаниуд хамтраад дэмжих хэрэгтэй. Андрайтерүүд нь ЖДҮ-ээс ашигтай ажиллаж чадах. Дунджаар жилийн хөрөнгийн эргэлт нь 500 саяаас дээш хэмжээний төслийг нь шалгаруулна. Хэтэрхий жижиг зүйл рүү хөрөнгийг оруулж болохгүй. Тухайн ЖДҮ компаниудыг хөрөнгийн зах зээлд бүртгээд хоёр гурван жил хөрөнгө оруулалт хийх замаар үйл ажиллагааг нь томруулах хэрэгтэй. Түүнийхээ дараа томруулаад жинхэнэ утгаар нь IPO хийлгэж болох юм. Тиймээс энэ олон талыг уулзуулах ажлыг төрөөс санаачилж болох юм. Ингэж чадвал манай хөрөнгийн зах зээл хөгжихийн зэрэгцээ дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж, ажлын байр бий болох гээд нийгэм эдийн засгийн олон эерэг үр дүнг авчирна” гэсэн юм. Энэ мэт дотоодоос хамаарах хөрөнгийн зах зээлийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг идэвхжүүлж чадвал гаднын хөрөнгө оруулагчид Монголын зах зээлд орж ирнэ.

### Сонголт

Монголчууд гаднын хөрөнгийн биржээс хэдэн сая ам.доллараар хэмжигдэхүйц хэмжээний хувьцаа авдаг аж. Монголбанкны мэдээлснээр монголчууд өнгөрсөн оны эхний хагас жилд гаднын хөрөнгийн биржүүдээс 109 сая ам.долларын хувьцаа авсан байна. Гэтэл манай хөрөнгийн бирж дээр тухайн жилийн мөн үед ердөө л 12.3 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ. /Энэ нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 80 орчим хувиар буурсан үзүүлэлт юм. Монголчууд гаднын зах зээлээс хувьцаа аваад байгаа эхний шалтгаан бол хууль эрх зүйн орчин байсан. Харин одоо бол энэ байдал шийдэгдсэн. Гэхдээ гаднын зах зээлд дурлах өөр шалтгаан нь хувьцааны өгөөжтэй шууд холбоотой. МХБ дээр гарсан хувьцааны ихэнх нь

### Гадаадын болон дотоод хөрөнгийн биржээс монголчуудын авсан хувьцаа (төгрөгөөр)



унтаа байдаг бол гаднын хөрөнгийн бирж дээрх хувьцаа ашиг их хөрвөх чадвар өндөр байдаг гэх. Дээрээс нь ил тод мэдээлэлтэй, өгөөж өндөртэй дотоодын уул уурхайн компаниуд нь монголчуудын хувьцааны мэдлэг дутмагаас МХБ-ийг голдог аж. Тиймээс учирч өгдөггүй талуудын энэ мэт сонирхлыг уулзуулах ажлыг МХБ болон СЗХ-ноос шат дараатай хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэгж чадвал 2014 онд Монголын үнэт цаасны зах зээл нойрноосоо сэрнэ. ■

### МХБ-ИЙН ГИШҮҮН БРОКЕР ДИЛЕРИЙН КОМПАНИЙН 2013 ОНЫ II УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ


/эхний 15 компани/

ТЭНГЭР КАПИТАЛ	МЭРГЭН САНАА
Нийт хөрөнгө 156,086,307.53	Нийт хөрөнгө 114,950,254.05
Эргэлтийн хөрөнгө 143,782,213.23	87,661,444.05
ЕВРАЗИА КАПИТАЛ МОНГОЛИА	БИ ДИ СЕК
Нийт хөрөнгө 1,206,260,478.87	Нийт хөрөнгө 9,594,029,988.25
Эргэлтийн хөрөнгө 1,124,347,877.22	5,964,907,989.58
ГАЦУУРТ ТРЕЙД	ӨНДӨРХААН ИНВЕСТ
Нийт хөрөнгө 300,559,039.28	Нийт хөрөнгө 61,263,591.40
289,394,184.79	52,869,934.40
АРД КАПИТАЛ ГРУПП	АЛТАН ХОРОМСОГ
Нийт хөрөнгө 1,261,094,113.00	Нийт хөрөнгө 66,983,649.58
1,243,165,943.00	66,238,721.70
МАСДАК	БУЛГАН БРОКЕР
Нийт хөрөнгө 63,730,140.80	Нийт хөрөнгө 115,996,269.94
44,114,240.80	81,342,103.83
САНАР	ДАРХАН БРОКЕР
Нийт хөрөнгө 49,988,041.25	Нийт хөрөнгө 55,268,331.77
41,501,202.25	18,268,825.77
ЗЭРГЭД	МОНСЕК
Нийт хөрөнгө 91,453,178.36	Нийт хөрөнгө 271,758,847.13
37,978,732.36	259,555,362.16


**ТООН МЭДЭЭ**

Банкны салбарын үндсэн үзүүлэлтийн 2009-2013 оны IV улирлын хоорондох гүйцэтгэл болон 2015 он хүртэлх төсөөлөл


Санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь




Нийт активийн жилийн өсөлтийн хувь




Зээлийн жилийн өсөлт (хувиар)




Мөнгөний нийлүүлэлтэд эзлэх банкнаас гадуурх мөнгөний хувь




Хадгаламжийн жилийн өсөлт (хувиар)




Зээлийн хүү (хувиар)




Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Хадгаламжийн хүү (хувиар)



Таван жил хүртэлх хугацаатай хэвийн зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголын банкны академи

IPO

# ХҮЛЭЭХИЙН УЧИР

## Ч.ЛУТАА


Хамтарсан Засгийн газрын үед буюу 2011 онд иргэн бүр “Эрдэнэс тавантолгой” компанийн 1072 ширхэг хувьцааг үнэгүй эзэмших шийдвэр гарсан. Тухайн үед иргэд эргэлзээ, хүлээлт, сонголтын дунд байв. Түүнчлэн уг шийдвэрийн хэрэгжилт өнөөдрийг хүртэл бүрхэг хэвээр л байна. Албаны мэдээллээс харахад одоогоор нэг сая иргэн хувьцаа авах сонголтыг хийжээ. Үлдсэн 1.8 сая иргэний хувьд сая төгрөгөө бэлнээр авах өргөдөл өгсөн байна. Гэтэл хувьцааны эзэд ногдол ашгаа хүртээгүй. Засгийн газарт хувьцаагаа нэг сая төгрөгөөр зарах хүсэлт гаргасан иргэд ч мөнгөө аваагүй хоёр жилийн нүүрийг үзэж байна. Учир нь Засгийн газрын 2012 оны дөрөвдүгээр сарын 11-ний 181 дүгээр тогтоолын дагуу хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа нь ямар нэг саналын эрхгүй. Аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэхээр заасан. Хөрөнгийн биржид хувьцаагаа гаргасны дараа, Засгийн газраас тогтоож өгөх хугацааг зарласнаар “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж нь хувьцаагаа худалдах, арилжаанд оруулах боломжтой гэж байгаа. Гэтэл өнөөдрийг хүртэл энэ харилцаа үүсээгүй л байна. Товчхондоо Засгийн газарт хувьцаа худалдах өргөдлөө гаргасан 1.8 сая иргэн нэг сая төгрөгөө хүлээсээр. Хувьцаа хэзээ ашгаа өгөх бол гэж горьдсон нэг сая иргэн мөн л ногдол ашгаа горьдсоор сууна. Одоогийн



Тавантолгойн цахилгаан станц

байдлаар улсын хэмжээнд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 хувьцааг эзэмшигч 710 мянга гаруй байна. Харин 536 хувьцаа эзэмшигч 11 мянга гаруй иргэн байгаа аж. Мөн хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнууд гээд нийт 300 мянган иргэн сая төгрөгөө бэлнээр авчээ.

### Хөрөнгө оруулалтын дүн (15 тэрбум төгрөг)




### Хүлээхийн учир

Хувьцааг үнэд хүргэх нь хамгийн чухал. Үүний дагуу хувьцааныхаа тодорхой хувийг олон улсын хөрөнгийн бирж дээр гаргаад зарах юм бол “Эрдэнэс тавантолгой”-н хувьцаа үнэд орж, иргэд хувьцааны

ногдол ашгаа хүртэх боломжтой. Уг ажлыг 2013 онд эхлүүлж, Монголын хөрөнгийн биржээр дотоодод арилжаалагдах хувьцааг эргэлтэд оруулна гэж байсан ч худлаа болчихсон. “Эрдэнэс Тавантолгой”-н захирал Я.Батсуурь “Дэлхийн зах зээлийн байдал муудсан, нүүрсний үнэ унасан. Ийм үед хувьцаагаа гаргавал компанийн үнэлгээ буурч, хувьцааны ханш унах болно. Тиймээс ч бүр 2015 оноос л хувьцаагаа гаргах асуудлыг ярина” гэв. Тэгэхээр монголчууд 2015 оноос л хувьцаагаа жинхэнэ утгаар нь эзэмшинэ гэсэн найдвар тээж суухаас өөр аргагүй.

Уг нь эртхэн шиг олон улсын зах зээлд хувьцаагаа гаргачихаж болмоор. Гэтэл сөрөг шалтгаан нь нүүрсний үнэ унаснаас гадна өөр нэг асуудал бий. Тэр нь “Чалко”-д төлөх өр. 2013 оны эцсээр урд хөршийнхөнд төлөх өрийн хэмжээ 160 сая ам.долларын үлдэгдэлтэй гарчээ. “Эрдэнэс Тавантолгой”-н хувьд нэг тонн нүүрсээ 40 ам.доллараар тооцон өрнөөсөө суутгуулах замаар урд хөрш рүү нүүрсээ экспортолж байгаа. Тонн нүүрсийг 40 ам.доллараар худалдана гэж тооцвол нийтдээ гурван сая тонн нүүрс экспортлох болно. Тэгж байж л “Эрдэнэс Тавантолгой” өрнөөсөө бүрэн салахаар байгаа юм. Үүнээс ▶

### Анхны хөрөнгө оруулалтын дүн (10 тэрбум төгрөг)



► хоёр сая тонныг нь олборлочихсон байгаа аж. Мөн нэг сая тонныг олборлоход бэлэн болгож, хөрсийг нь хуулчихсан гэнэ. Уг нь яамныхны мэдэгдэж байснаар “Чалко”-гийн өрийг 2013 ондоо барагдуулж дуусах ёстой байсан. Гэтэл тээвэрлэлтийн асуудлыг одоо хүртэл шийдэж чадаагүй. Төмөр замгүй “Эрдэнэс тавантолгой” ХК өрөө төлж чадахгүй. Нүүрс нь үнэд хүрэхгүй байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн далангийн ажил 50 хувьтай явагдаж байна. Өрөө төлж чадаагүй компани ямар юмных нь хувьцааны ашиг өгөх билээ. Тус компанийн хувьд олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргаж, мөнгө олж чадахгүй байгаа өөр нэг том шалтгаан нь энэ.

### Эргэлзээ

1072 хувьцаа хэзээ ашгаа өгөх вэ гэдэг яах вэ цаг хугацааны асуудал гэж хэлэх хүн байна. Харин нэг сая төгрөгөө авах хүсэлт гаргасан иргэд мөнгөө хэзээ авах вэ. Уг нь иргэдийн Засгийн газарт худалдсан хувьцааг дотоодын Хөрөнгийн бирж дээр Монголын компаниудад арилжаалж эхэлсэн. Гэтэл хувьцааг худалдан авах гээд дугаарлаж байсан үндэсний компаниуд сүүлийн үед хувьцаагаа буцаан өгч, мөнгөө авахыг хүсэх болсон. Шалтгаан нь өнөөх л Тавантолгойн хувьцаа дээрх үнэд хүрэхгүй байгаатай холбоотой. Тиймээс үнэлэмж нь буураад байгаа “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг ирэх оноос буцааж, компаниудад мөнгийг нь эргүүлж өгөхөөр болсон. Товчхондоо хувьцаа зарагдаагүй.

Тиймээс сая төгрөгөө авах гэсэн иргэдийн хүсэлтийн хариу хэзээ ирэх нь тодорхойгүй болчихоод байна. Ямартай ч дээр дурдсан олон асуудал шийдэгдээд “Эрдэнэс тавантолгой” ашигтай ажиллаад олон улсын зах зээлээс хөрөнгө амжилттай босгож чадвал Засгийн газар нэг сая төгрөгийг иргэддээ өгөх л байх.


### Гэхдээ

Хувьцаагаа сая төгрөгөөр солих хүсэлт гаргасан иргэд хоёр гурван жил хүлээсний эцэст түүнийгээ гар дээрээ авах нь хэтэрхий “тэнэг наймаа” гэдгийг анхааруулах хүн олон. “Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах төв” ТББ-ын тэргүүн Э.Алтаншагай “Сүүлийн үед иргэдийн зүгээс нэг сая төгрөг авахаас татгалзаж хувьцаагаа авахаа илэрхийлэн тус ТББ-д олноор хандаж буй. Одоогийн байдлаар 1000 гаруй өргөдөл ирээд байгаа. Энэ нь ч аргагүй. Иргэдийн хувьд нэг сая төгрөг авснаас хувьцаагаа авсан нь хамаагүй ашигтай. Нэг ширхэг хувьцааны нэрлэсэн үнэ 932 төгрөг байгаа. Энэ үнэ өснө үү гэхээс буурахгүй. Ирээдүйд нэгж хувьцааны үнэ хамгийн багадаа 10 мянган төгрөгт хүрэх тооцоо байна. Иргэн бүр банкинд данстай байдаг шиг үнэт цаасны данстай байх хэрэгтэй” гэсэн юм. Гэтэл мөнгө бэлнээр авахаар өргөдлөө өгсөн иргэдийн хувьд сая төгрөгөө аваагүй. Үнэт цаасны дансаа нээлгэж хувьцаагаа авъя гэхээр болохгүй. Учир нь сая төгрөг авах өргөдөл өгсөн тул хувьцаа нь дансанд нь орохгүй түгжигдчихээд байна. Ийм нөхцөлд 1.8 сая иргэн мөнгө ч үгүй хувьцаа ч үгүй үлдэх эрсдэл үүсээд байна.

### Таамаг

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт нөөц 6.4 тэрбум тонн. Засгийн газрын тооцоолсноор ирэх онуудад Тавантолгойн нүүрсийг 100 ам.доллар ба түүнээс дээш үнээр борлуулахаар төлөвлөөд байгаа. Энэ тооцооллын дагуу ийм хэмжээний нүүрсийг 100 ам.доллараар борлуулбал “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 640 тэрбум ам.долларын хөрөнгөтэй компани болох

### Ирээдүйд хүртэх орлогын дүн (600 тэрбум төгрөг)



юм. Өнөөдөр 640 тэрбум ам.долларын хөрөнгөтэй компани дэлхий дээр цөөхөн бий. “Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах төв” ТББ-ын мэргэжилтнүүдийн гаргасан судалгаагаар 10 жилийн дараа нэг ширхэг хувьцаа олон улсын болон дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалах үнэ багадаа 10 мянган төгрөгийн өртөгтэй болж өсөхөөр байгаа аж. Өнөөдрийн байдлаар нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 932 төгрөг байгаа. Энэ тооцоогоор бол одоо нэг сая төгрөгийн үнэ хүрч байгаа 1072 хувьцаа ирээдүйд 60 орчим сая төгрөгийн өртөгтэй болж магадгүй аж. Түүнчлэн 2016 оноос жилд дунджаар 20 сая тонн нүүрс олборлоно гэж байгаа. Уг төлөвлөгөөгөөр тус ордын нөөц дуусах хүртэл 320 жил болно. Тиймээс яаж ч бодсон иргэд өнөөдөр маргаашгүй сая төгрөгөө гар дээрээ авч чадахгүйгээс хойш хувьцаагаа авах нь зөв шийдвэр байж болох юм. Хэрвээ иргэн та сая төгрөгөө авахгүй. Хувьцаагаа авах хүсэлтэй байвал “Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах төв”-д хандаж, Засгийн газарт өргөдөл гаргах боломжтой аж. Гэхдээ Засгийн газар танд хувьцааг тань буцаан өгөх эсэх нь эргэлзээтэй. Одоогоор энэ талаар сураг чимээ гараагүй л байна. Ямартай ч “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ы 1072 ширхэг хувьцааныхаа оронд нэг сая төгрөг авна гэсэн иргэдэд хувьцаа буцаан авах боломж олгож өгөхийг “Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах төв”-өөс Засгийн газарт хүсэхээр болжээ. ■



# ШИЛДЭГ СЭТГҮҮЛ, ШИНЭ ҮНЭЛЭМЖ

Уншигч захиалагчидтайгаа манай сэтгүүлийн зүгээс шинэ оны эхэнд хуваалцах баярт мэдээ байгааг дуулгахад таатай байна. “БАТЛАМЖ. *Mongolian Economy* сэтгүүлийн хамт олонд: Монголд үндэсний сэтгүүл зүй үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойн жил-2013 онд мэргэжлийн ур чадвар, ёс зүй, бүтээл туурвилаараа сэтгүүлүүдийг манлайлсан тул Танай байгууллагыг “Монгол Улсын 2013 оны шилдэг сэтгүүл”-ээр тодруулж батламжлав. Монголын сэтгүүлчдийн эвлэлийн Ерөнхийлөгч Б.Галаарид. Эндээс та бидний хамтын ололт амжилтын нэгэн өнгө харагдаж буй.

Манай хамт олны нэгэн жилийн хичээл


зүтгэлийн үр дүн дээрх батламжаар илэрч байгаа. 2013 онд “Mongolian Economy” эдийн засаг, бизнесийн сэтгүүлээ 14 хоног тутам уншигчдын гарт хүргэсэн. Үүний сацуу Давосын дэлхийн эдийн засгийн чуулган, Монгол, Их Британи улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан сэтгүүл зэрэг цөөнгүй тусгай дугаар бэлтгэсэн. Мөн [www.Mongolianeconomy.mn](http://www.Mongolianeconomy.mn) цахим хуудсын шинэчлэлийн ажлыг Австралийн зөвлөх мэргэжилтний тусламжтайгаар эхлүүлсэн. Түүнчлэн “Economy” студийнхээ анхны нэвтрүүлгийг телевизээр цацсан... гээд олон амжилтыг тоочиж болох байна.

Монголын хэвлэл мэдээллийн

салбарын шилдгийг шалгаруулах хүндэтгэлийн ёслол дээр манайхан “Шилдэг сэтгүүл”-ийн батламжийг гардаж авах мөчид “Эдийн засгийн мэдээллийг монгол-англи хэл дээр олон улсын стандартаар уншигч олон нийтэд хүргэж, мэргэжлийн сэтгүүл зүйн чиг хандлагыг тодорхойлж яваа” гэж тодотгон зарлаж байсан билээ. Энэ бол өнөөгийн Монголын сэтгүүл зүйн онцгой үнэлэмж юм. Хэдийгээр “Mongolian Economy” сэтгүүл нь цөөн жилийн түүхтэй ч ийм үнэлгээ авах хэмжээнд хүрч байгаа нь бидний бахархал. Энэ нь цаашид бүтээлч үйлсээ улам хөгжүүлж, захиалагч уншигч та бүхэнд илүү чанартай, их чамбай мэдээлэл түгээхийн төлөө хичээхийг бидэнд бас даалгаж буй хэрэг юм. Тиймээс манай хамт олон уг даалгаврыг чадварлаг чанартай биелүүлэхийн тулд 2014 ондоо нөр хичээнгүйлэн ажиллах болно. Эрхэм уншигч таны мэргэн санаа, санал тань энэ бүхэнд эрч хүч болох тул бидэнтэй эргэх холбоотой байхыг эл дашрамд хүсье.

“Mongolian Economy”  
сэтгүүлийн редакци ■

## ТОП-20



## Санхүүгийн тайлан

**Өөрийн хөрөнгө:** 18 тэрбум төгрөг

**Үйл ажиллагааны зардал:** 2.1 тэрбум төгрөг

**Цэвэр ашиг:** 1.3 тэрбум төгрөг

**Ногдол ашиг тараасан эсэх:** Нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашиг тараасан.

**Өр зээл:** Европын банкаас еврогийн зээлтэй. 2014 оны арваннэгдүгээр сард зээлээ дуусна.

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

**удирдлага сургалтад сууж, гэрчилгээ авсан эсэх:** Тал хувь нь сургалтад сууж, гэрчилгээ авсан.

**Нийт ажилтны тоо:** 670. Үүний 450 нь үйлдвэрийн ажилтан.

**Байгууллагын эрхэм зорилго:** Орчин үеийн дэвшилтэд техник технологиор хүнсний аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүнийг цэвэр үйлдвэрлэлийн зарчмаар үйлдвэрлэн, шинэ хэрэглээг бий болгож, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах.

**Үйл ажиллагааны төрөл:**

**Хүнсний аюулгүй байдлын хувьд:** Компанийн итгэмжлэгдсэн микробиологийн болон химийн хоёр лабораторид мэргэшсэн инженерүүд ажиллаж, түүхий эд материалаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх дамжлага тус бүрт хяналт тавин ажилладаг.

**Техник, технологийн шинэчлэл:** 2003 оноос нэвтрүүлсэн инновацийн хөтөлбөрийн хүрээнд 2004 онд дугуй талх үйлдвэрлэх компьютерийн удирдлагатай иж бүрэн шугам ашиглалтад оруулсан.

2006 онд зууван болон дөрвөлжин хэлбэрийн талх үйлдвэрлэж, стандартын дагуу зүсэж савласан талхны хэрэглээг бий болгосон.

2008 онд “Милл хаус” үйлдвэрээс “Атар” гурилыг шуудайгүйгээр тээвэрлэх тусгай зориулалтын 20 тоннын даацтай машиныг Герман, Украин улсад захиалгаар хийлгэж, авчирсан.

2011 онд нарийн боов үйлдвэрлэлийн орчин үеийн дэвшилтэд техик, технологи нэвтрүүлж, зохицуулах үйлчилгээтэй бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэв.

2012 онд зууван хэлбэрийн талх үйлдвэрлэх урсгал шугам суурилуулж, лууван, олон үр, эрдэнэшиш зэрэг нэмэлт түүхий эдээр баяжуулсан дөрвөн төрлийн талх худалдаанд гаргасан.

2013 онд талх савлах бүрэн автомат машин суурилуулсан нь компьютер хяналт, лазер мэдрэгч, уутны ам нээгч, ам боогч зэрэг бүх тоноглолыг агуулсан орчин үеийн савлагааны технологийг Монголд анх нэвтрүүлэв.

2014 оны гуравдугаар сард багтаан бялуу, нарийн боовны үйлдвэрлэлийн шугамаа бүрэн автомат болгон шинэчлэх. Дээрх хугацаанд нийтдээ 20-иод тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. ▶



“Талх чихэр” ХК-ийн талх, нарийн боовны үйлдвэр. 2013.12.13

## И.ОТГОН

**Компанийн нэр:** “Талх чихэр комбинат” нэртэйгээр 1984 онд ашиглалтад орж, 1999 онд хувьчлагдан “Талх чихэр” ХК болсон.

**МХБ дэх арилжааны симбол нэр:** ТСК

**Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо:** 4200. Үүний 30-аад хувь нь жижиг хувьцаа эзэмшигчид.

**ТУЗ-ийн гишүүний тоо:** 10 /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга орсон/

**ТУЗ-ийн хараат бус гишүүний тоо:** Дөрөв

**Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх**

Эдүгээ 30 дахь жилдээ талх, нарийн боов, бялуу, чихэр, жигнэмэг зэрэг 60 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Монголын ууган хүнсний үйлдвэр юм.

**Ижил төрлийн үйлдвэрүүдээс ялгарах давуу тал:** Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр талх, нарийн боовны нэр төрөл, хэлбэр хэмжээнээс гадна хэрэглээг өөрчлөн, орц найрлагыг нь байгалийн гаралтай амин дэмээр баялаг нэмэлт түүхий эдээр баяжуулан эрүүл мэндэд тустай зохицуулах үйлчилгээтэй хүнс үйлдвэрлэдэг. Нийт бүтээгдэхүүний 40 гаруй хувь нь органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнс.



► **“Талх чихэр” компанийн гүйцэтгэх захирал М.Базар-Ууганд компанийн засаглал, компанийн нийгмийн хариуцлагатай холбоотой цөөн асуулт тавьж, хариулт авлаа.**

**-Компанийн гүйцэтгэх удирдлага хуулиар ТУЗ-өөс хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулах статустай байдаг. Танай ТУЗ гүйцэтгэх удирдлагадаа хэр итгэл өгч, ойлголцож ажилладаг вэ?**

-Компанийн тухай хууль болон бусад хууль дүрэмд заасны дагуу “Талх чихэр” компанид Гүйцэтгэх удирдлага хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр ажилладаг. Би ч гэсэн тийм л зарчмаар ажиллаж байгаа. Үүнийхээ хүрээнд ТУЗ-өөс надад тодорхой хэмжээний эрх мэдэл өгөхийн сацуу үүрэг даалгавар, төлөвлөгөө өгнө. Мэдээж ямар ч компани ашгийн төлөө байх ёстой учраас эхний ээлжинд ашгийн болон борлуулалттай холбоотой төлөвлөгөө байна. Нөгөө талаас нийгмийн хариуцлагын болон нийт ажилчдад чиглэсэн бүтээн байгуулалтад ямар ажлууд хийх вэ гэдэг үзүүлэлтээр гүйцэтгэх удирдлагын ажлыг дүгнэдэг.

**-Та “Талх чихэр” компанийн**

**гүйцэтгэх захирлаар хэдэн жил ажиллаж байна. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр хэр туршлагатай хүн бэ?**

- “Талх чихэр” компанийн гүйцэтгэх захирлаар өнгөрсөн оны гуравдугаар сарын 11-нд томилогдсон. “Женко” группт бол арваад жил ажилласан.

**-Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр томоохон ямар ажил хийж байна вэ?**

-Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд манайх эрүүл зөв, цэвэрч боловсон орчинд ажиллаж, амьдрахыг чухалчилдаг. Хүнсний үйлдвэр тамхи, архитай байж болохгүй гэдэг үүднээс Алкоголгүй хүнс үйлдвэрлэгчдийн холбооны гишүүн бөгөөд ажлын байрны ойр орчимд болон ажилчдын дунд архи, тамхигүй орчин бүрдүүлж чадсан. Мөн энэ оны эхээр ажилчдын алжаал тайлах өрөө буюу фитнес төв ашиглалтад оруулна. 200-гаад сая төгрөгийн тоног төхөөрөмж БНСУ-аас орж ирээд, 100 гаруй сая төгрөгийн тохижуулалт хийж байгаа. Энэ нь нэг талаасаа 2014 онд тохиож байгаа “Талх чихэр” компанийн 30 жилийн ойг угтсан арга хэмжээнүүдийн нэг. Түүнчлэн 24 цагаар ажилладаг хүнсний үйлдвэр маш халуун, чийглэг орчин байдаг. Тиймээс ажлын байрны агааржуулалтыг 800-гаад сая төгрөгөөр шийдвэрлэсэн. Энэ оны гуравдугаар сард ашиглалтад оруулах боовны чаналгын шугам дээр мөн 200 гаруй сая төгрөгийн өртөгтэй агааржуулах систем шинээр тавьж байгаа. Энэ бүхэн бол ажлын байрны ая тухтай орчинг хангах явдал юм.

**-Танай нийт ажилчдын хэдэн хувь нь эмэгтэй вэ?**

-Манай үйлдвэрийн 670 ажилтны 55 хувь эмэгтэй, 45 хувь нь эрэгтэй. Нийт ажилчдын хувцас солих өрөөг маш сайхан тохижуулж, засварлахаас гадна ажилтнуудад зориулсан угаалгын машин хүртэл суурилуулсан. Ажилчид шүршүүр юм уу, саунд орох эсвэл фитнесээр хичээллэх хоорондоо хувцасаа угаалганд өгөөд, хатаалгаад авчихна. Мөн үйлдвэрийнхээ ажилчдад зориулсан автосервис нээж байгаа.

Нэг үгээр хэлбэл, ажилчид маань ажлын цагаар юунд ч санаа зовохгүй ая тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрэн бүрдүүлэхийн төлөө нэлээд хөрөнгө оруулалт хийж байна.

**-Танай компани шинэ жилд зориулж мөсөн хотхон барьдаг. Үүнд хэчнээн төгрөг зарцуулдаг вэ?**

-Манай Сонгинохайрхан хамгийн их хүн амтай, тохижилт муутай дүүрэг. Тиймээс манай компани 2012 онд шинэ жилээр үйлдвэрийнхээ харалдаа төв зам дагуу мөсөн хотхон барьсан. Дүүргийн оршин суугчид маш их сонирхож, хүүхэд багачууд зугаацаж, бөөн баяр хөөр болж байхыг хараад бид их баяртай байсан. Тиймээс 2013 онд мөсөн хотхоноо улам гоё болгож 50 гаруй сая төгрөг зарцуулж, арваад мэргэжлийн уран барималч залуугаар хийлгэсэн. Бидэнд маш их таалагдаж байгаа. Хүн ч их ирж байна.

**-Ажилчдынхаа цалинг хамгийн сүүлд хэзээ нэмсэн бэ?**

-Өнгөрсөн оны зургадугаар сараас валютын ханш огцом өссөнтэй холбоотойгоор өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өссөн. Үүнтэй уялдаад ажилчдынхаа цалинг арав, арваннэг, арванхоёр, нэгдүгээр сар гэсэн дөрвөн үе шаттай 20-25 хувиар нэмж байгаа. 670 хүний цалинг нэг дор нэмэхэд хүндрэлтэй л дээ. Ингэснээр манай дундаж цалин 600 мянган төгрөг болж байгаа.

**-Талх, нарийн боовны зах зээлд эзлэх байр сууриа ойрын ирээдүйд хэр ахиулах төлөвлөгөө байгаа вэ?**

-Манай маркетингийн албаны хийсэн судалгаагаар бялуу, нарийн боовны төрлөөр бид зах зээлд 4-5 дугаар байрт явж байгаа. Шинэ онд энэ байраа мэдээж урагшлуулж нэг хоёр руу оруулж ирэхийг хичээнэ. Үүнд түлхэц болох гол зүйл нь бялуу, нарийн боовны үйлдвэрлэлд хийгдэж байгаа автомат шугамын шинэчлэл байх болно. Ингэснээр бүтээгдэхүүний амт чанар, нэр төрөлд ч өөрчлөлт орж, өрсөлдөх чадвар дээшилнэ гэж үзэж байгаа. Ер нь манай компани техник, технологийн шинэчлэлийн хувьд “Европ стандартыг Монголд” гэсэн уриатай ажилладаг. ■

## БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

# ГЭРЭЭГ АМЖИЛТТАЙ БАЙГУУЛАХАД ЮУГ АНХААРАХ ВЭ?

## Х.ХУЛАН

Олон улсын бизнесийн түншүүдтэй харилцахад тухайн улсын соёл заншил томоохон үүрэг гүйцэтгэдэг. Эдгээрийг мэдэхгүй бол хамтын ажиллагаа амжилттай байж чадахгүй. Тухайлбал, болгарчууд толгойгоо сэгсэрвэл юу гэсэн үг вэ? Таны бизнест тустай мэдээллийг дараах улс орнуудын жишээн дээр толилуулж байна.

## Хятад Улс

Урд хөршийн бизнес түнш танд хэзээ ч “Үгүй” гэж хэлэх юм уу татгалзсан хариу өгөхгүй. Тэд шууд “Тийм”, “Үгүй” гэж хэлэхийн оронд таны урдаас зөрүүлж асуулт тавина. Эсхүл сэдвээ өөрчлөх юм уу таны анхаарлыг сарниулахын тулд “Таны хэлэх гэж байгаа санааг ойлгож байна” гэнэ. Хэрвээ хамтрах ажлын саналыг тань хүлээж авалгүй татгалзсан бол санал болгогч тал өөрийн шаардлага, бэлтгэлээ хангалттай сайн бэлдээгүй гэсэн үг. Хятадууд санал тавьж буй тал хариуцлагаа хамт хүлээж, ажлын хэрэгжилт дээр ч гэсэн анхаарах ёстой гэж үздэг.

Кёльн хот дахь Карл Дуисбург төвийн хятад судлаач Хельга Граббе: “Та бизнесийн түншдээ бүх ажил үүргийг хамтран хариуцаж, зөвхөн нэг талд тохож үлдээхгүй гэдгээ сайтар ойлгуулах хэрэгтэй” гэж зөвлөж байна.

Та анх удаа хятад түншийнхээ бизнес зоогт уригдсан бол гомдоохгүйн тулд тэмээний тавхай, гэдэс дотор заавал идэх албагүй. Харин ердийн бус хоолоор дайлах нь Таныг төдийчинээ хүндэтгэж байгаагийн илрэл гэдгийг мэдвэл зохистой. Та хоолоо идэлгүй тавган дээрээ үлдээсэн ч түнш тань гомдохгүй. Бизнесийн зоог барих ёслол нь хоёр тал дотно танилцах зорилготой байдаг. Хельга Граббе: “Хятадууд урьд нь өөрсдийн сайн танил хүмүүстэй л гэрээ хэлэлцээр байгуулдаг байсан түүхтэй” хэмээв. Өнөө үед харин бизнесийн түнштэйгээ тухтай танилцах цаг зав бага тул гэрээ хэлэлцээр хийх шат дамжлага багассан. Гэсэн хэдий ч хятадууд бизнесийн гэхээсээ өмнө таныг хувь хүн талаас чинь эхэлж хардаг. Үүн дээр үндэслэж цаашдын хамтын ажиллагааны суурийг тавьдаг. Бизнесийн зоогийн үеэр түншүүд тань гэр бүл, чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөдөг тухай асуух нь хэвийн үзэгдэл гэдгийг анхаарна уу.

## Болгар Улс

Болгар бизнесийн түншийн дохио зангаанд найдваас Та төөрөгдөлд орох магадлалтай. Учир нь тэдний толгойгоо сэгсрэх нь зөвшөөрч, хоёр удаа толгой дохивоос татгалзаж байгааг илэрхийлдэг. Ярианы үеэр болгарчууд дуугаа өндөрсгөж, гараараа дохих нь ихэсвэл уурлаж

байгаа гэсэн үг биш. Харин ч ярианы сэдвийг ихэд сонирхож буйн шинж. Түүнчлэн болгарчууд мэдээллийг шууд бус замаар солилцдог. Өөрийн бодож санаж байгаагаа шууд илэрхийлэх нь бүдүүлэг зан гаргаж буйн хэлбэр болно. Тухайлбал, Та өрөөний цонхыг онгойлгохыг хүсэж байвал хүсэлтээ асуулт болгож хэлнэ үү. Соёл судлалын сургагч багш Мирелла Симеонова: “Та цонх онгойлгуулахыг хүсэж байвал хажуудаа сууж байгаа хүнээс Танд ч гэсэн өрөө бүгчим санагдаж байна уу гэж асуугаарай”.

Албан тушаал, зэргээр ялгаварлах үзэгдэл Болгарт түгээмэл. Тухайлбал, байгууллагын хурлын үеэр дарга бусад ажиллагсдаас илүү их ярьж илтгэдэг. Ийм хурал цуглааны явцад ажиллагсад даргадаа ямар нэгэн шинэ санаа, сайжруулах зөвлөгөө дэвшүүлдэггүй. Шинэ санаачилгын талаар даргатайгаа хоёулаа уулзахдаа хэлж ярилцдаг байна.

Болгарчууд нэг дор олон ажил амжуулдаг. Хурлын үеэр утсаар ярьж, мессеж болон мэйл бичих эсхүл өрөөнөөс түр гарч явах нь хүндэтгэлгүй хандаж байгаа гэсэн үг биш. Та болгар түншийнхээ гэрт уригдсан бол гарын бэлэг авчрахаа мартуузай. Жишээ нь, гэрийн эзэнд шил дарс, эзэгтэйд цэцэг өгөх тохиромжтой. Сондгой тоотой цэцэг аваарай. Учир нь тэгш тоотой цэцгийг оршуулганд хэрэглэдэг гэж Мирелла Симеонова тайлбарлаж байна. ▶

## ► Саудын Араб

Бизнесийн эхний дүрэм: тэвчээртэй бай! Эхний уулзалтуудыг бизнесийн түншүүд бие биенээ таньж мэдэхийн тулд хийдэг. Цахим шуудан, утсаар харилцахгаас илүү биечлэн танилцах явдал хамгийн чухал. Учир нь түншүүд хоорондоо таалагдах хэрэгтэй. “Ориент-Оксидент” зөвлөх үйлчилгээний компанийн ажилтан Сильвия Ортлийб: “Гэрээ хэлэлцээрийн явцыг түргэсгэхийг хүсэн, тэвчээргүй зан гаргаваас бизнес бүтэлгүйтэх болно”.

Талууд уулзалтын үеэр хууч хөөрөх нь чухал байдаг. Спорт, ялангуяа хөл бөмбөгийн талаар ярих нь хэзээ ч таалагдана. Түүнчлэн өөрийн гарал үүсэл, гэр бүлийн тухай асууж болно. Гэхдээ саудийн араб түншээсээ түүний эхнэрийн талаар хэзээ ч бүү асуу. Улс

төр, шашин шүтлэгийн сэдэв мөн ярих сэдэв биш гэдгийг сайтар санаж яваарай.

Саудын Арабын Вант Улс лалын шашинтай. Иймд лалын шашны анхны мэдэгдэхүүнтэй байваас зохимжтой. Рамаданы үеэр мацаг барьдаг тул хоол унд, тамхи татах хориотой. Таны бизнесийн түнш мацаг барих явцдаа танаас цай уух уу гэж асуувал ёс заншлыг нь хүндэтгэж үзээд татгалзсан нь дээр. Ер нь бизнесийн аяллаа Рамаданаас бусад үед уулзахаар тохирох хамгийн оновчтой шийдэл мөн. Түүнчлэн уулзах цагаа товлохдоо тэдний мөргөлийн үеийг анхааралдаа авах хэрэгтэй.

Бизнесийн түншүүдийн нийгэмд эзлэх байр суурь томоохон үүрэгтэй. Өөрсдийн түвшинд эн зэрэгцэх компаниуд хоорондоо ихэвчлэн түншилдэг. Статусаар

доогуур түншүүд байваас бизнесийн хэлэлцээр амжилтад хүрэхгүй. Өмссөн хувцасны чанарыг тухайн байгууллагтай мөн шууд холбож үздэг. Шүүмж хэлэхдээ тун болгоомжтой илэрхийлж, шууд татгалзсан хариу хэлдэггүй болохыг анхаарна уу.

Арабчууд цагийг яг таг баримталдаг. Та бизнесзоогт уригдсан бол яавч хоцорч болохгүй. Ширээнд суухдаа зочдын зэрэглэл, нийгмийн гарал үүслээс хамааралтай. Хамгийн чухал зочин гэрийн эзний хажууд сууна. Суудал гаргаж өгтөл хүлээж байх хэрэгтэй. Ажлаа зоог барихаас өмнө амжуулдаг. Түүнчлэн хооллох явцад их юм ярихыг цээрлэдэг. ■

Эх сурвалж: Германы “Die Zeit” сонин



Л.БЯМБААГИЙН БУЛАН

# 2014 ОНЫ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ



“Мандал Ассет Менежмент” даатгалын компаниас гаргасан 2013 оны хагас жилийн тайланд эхний хагаст үйл явдал, өөрчлөлт, өөдрөг байдлыг харуулсан талаар дурдсан. Гэхдээ эдийн засгийн суурь үзүүлэлт талаас харахад эдгээр нь үргэлж сайн байсангүй. Өнгөрсөн оны эдийн засгийн гүйцэтгэл бидний санасан шиг тийм ч сайн байгаагүй. Гэхдээ эдийн засаг хоёр оронтой тоотой өсөлтөө хадгалав.

## 2013 оны дэлхийн эдийн засаг

Дэлхийн эдийн засаг 2013 онд өсөх эсэх нь тодорхойгүй байв. Гэвч оны эцэс гэхэд илүү өөдрөг байдал ажиглагдах болсон. Өнгөрсөн онд санхүүгийн байгууллагууд жилийн эцсийн өсөлтийн таамгаа ялимгүй бууруулжээ. Тухайлбал, дэлхийн эдийн засаг 2.5 хувь, АНУ 1.7 хувь, БНХАУ 7.7 хувиар өснө, харин евробүс -0.4 хувиар буурна гэжээ.

Эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн байсан ч өсөлт гарсан байна. Ирэх жилүүдэд энэ өсөлтийн үр дүнд эдийн засаг илүү тогтвортой, уян хатан хөгжих боломжтой гэж найдаж байна.

## 2013 онд Монголын эдийн засаг

2013 онд Монголын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурч, валютын ханш тогтворгүй, инфляци өссөн, Чингис бонд гаргаж, гадаад худалдааны ихээхэн алдагдал хүлээсэн зэрэг олон асуудал тулгарсан. Бидний таамаглаж байсанчлан гадаадын шууд хөрөнгө оруулалтын санхүүжилтээс бондын санхүүжилт, уул уурхайгаас дэд бүтцийн хөгжил, хувийн хэвшлээс төрийн салбар рүү гэсэн эдийн засгийн шилжилт хийгдсэн.


Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан нь уг салбарын суурь муу, импортоос хамааралтай байдал, банкны салбарын эрүүл мэнд зэрэг нь эдийн засгийн

## 2013 оны ДНБ-ий өсөлтийн таамаг

	Дэлхий дахинд		АНУ		Евробүс		БНХАУ	
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Fitch	2.3	2.9	1.7	2.6	-0.4	0.9		
OECD			1.7	2.9	-0.4	1	7.7	8.2
Citibank	2.5	3.2	1.6	2.6	-0.3	0.8	7.6	7.2
World bank	2.2	3	2	2.8	-0.6	0.9	7.7	8
IMF	3.1	3.8	1.7	2.7	-0.6	0.9	7.8	7.7

Эх сурвалж: 2013 оны 6-12-р сарын байдлаар дээрх байгууллагуудаас авав

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт, %



▶ тааруухан суурь бүтцийг улам муутгажээ.


График 1-д макро эдийн засгийн эрүүл мэндийг зургаан үндсэн үзүүлэлт ашиглан гаргаж, 1-7 гэсэн оноогоор үзүүлэв (1 оноо хамгийн муу, 7 оноо хамгийн сайн). Хамрах хугацаа 2013 оны II, III улирал.

Энэ графикаас харахад 2013 оны III улиралд 4 оноотой байна. Энэ нь алдагдалгүй, бас ашиггүй байсныг харуулж буй. Мөн өмнөх оны энэ үеийнхтэй нь харьцуулахад 0.5 оноогоор сайжирсан. Гэвч өнгөрсөн оны I улирлаас 1.5 хувиар буурсан байна.

ДНБ-ий хоёр оронтой тоотой өсөлт, инфляцийн бууралт, чанаргүй зээлийн түвшин доогуур байсан нь сайн үр дүн гарахад нөлөөлсөн (Хадгаламж банкны тухайд банкны салбарын үзүүлэлтэд оруулж тооцоогүй)

Доошоо чиглэсэн үзүүлэлт нь валютын ханшийн савалгаа, гадаад худалдааны том алдагдал, төсвийн алдагдал зэргээс шалтгаалжээ.

Макро эдийн засгийн эрүүл мэндийн үзүүлэлт



Эх сурвалж: “Мандал Ассет Менежмент”

## 2014 онд эдийн засагт нөлөөлөх гол хүчин зүйлс юу байх вэ?

2014 онд эдийн засгийн гүйцэтгэлд голлон нөлөөлөх хэд хэдэн чухал хүчин зүйл байх болно.

### Улс төрийн тогтвортой байдал

2012 онд шинэчлэлийн Засгийн газар бүрэлдэж, 2013 онд Ерөнхийлөгчийн сонгууль тайван болсон. Гэвч улс төрийн тогтвортой байдал эргэлзээтэй хэвээр буй. 2013 онд Засгийн газрыг огцрохыг хэдэн удаа шаардсан. Хамгийн сүүлд Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд нарыг огцрохыг шаардсан нь тогтворгүй байдлын тод жишээ юм.

### Оюутолгой

Засгийн газар, “Оюутолгой”-н хооронд хийгдэж буй хоёр дахь шатны санхүүжилтийн хэлэлцээрийн үр дүн ямар байх нь голлон нөлөөлөх болно. Төслийн өнөөгийн шатны хэлэлцүүлэгт ахиц, дэвшил гарсан нь ч гүний уурхайн санхүүжилт шийдвэрлэгдээгүй хэвээр. “Оюутолгой” нь Монголын эдийн засагт, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалтад шууд нөлөө үзүүлэхээр байна.


### “Самурай” бонд

Монголын Хөгжлийн банкнаас “Самурай” бондыг гаргасан нь дэд бүтцэд өмнө нь хийгдсэн хөрөнгө оруулалтуудын эцсийн үр дүн ямар байхыг шийдвэрлэх болно.


### Монголбанкны бодлого

Моргейжийн зээлийг бууруулах болон бодлогын чанартай бусад хөтөлбөр нь 2013 оны гол сорилтуудын ▶


Жилийн инфляци, %



2013 оны гадаад худалдааны алдагдал, сая ам.доллар



2013 оны гадаад худалдааны алдагдал, сая ам.доллар



▶ хамт инфляцийн түвшин, валютын ханшийг хэвээр хадгалахад нөлөөлнө.

### 2014 оны хандлагууд

Засгийн газар хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах үүднээс зарим шийдвэртэй арга хэмжээ авч буй. Гэвч 2014 оны сүүлч хүртэл гадаадын шууд хөрөнгө оруулалт сайжрахгүй.

Монголбанк зорилтот инфляцийн түвшинг найман хувь байлгахар зарласан. Үр дүнтэй арга хэрэгсэл хязгаарлагдмал, төгрөгийн ханш хэлбэлзэлтэй байгаа зэргээс инфляци 12 хувьд хүрэх магадлалтай байна.

2014 онд гадаад худалдааны өсөн нэмэгдэж буй алдагдал зогсохгүй. Гэвч дэлхийн зах зээл дээр зэсийн ханш нэмэгдэж, “Оюутолгой”-н зэсийн экспорт гадаад худалдааны алдагдлыг бууруулах болно.

Валютын ханшийн хэлбэлзэл 2014 оны гол эрсдэл хэвээр байх болно. Бид гадаад валютын дотогш чиглэсэн томоохон урсгал байхгүй гэж харж байна. Нөгөө талаас Монголбанкны валютын нөөц багассан хэвээр байх болно.

### 2014 жилийн эцсээр хүлээгдэх үр дүн

ДНБ-ий өсөлт 2014 онд арав орчим хувь байх болов уу гэсэн хүлээлттэй байна. “Самурай” бондыг гаргаснаар 2013 онд эхлүүлсэн дэд бүтцийн төслүүд үргэлжилнэ. Уг бондын санхүүжилтээр 2014 онд эхлүүлэх хөгжлийн томоохон төслүүд ч цөөнгүй байна.

2013 онд инфляцийг бууруулахад гаргасан ахиц, дэвшлийг 2014 онд хадгалахад илүү хэцүү байх болно. Учир нь валютын ханш тогтворгүй, инфляцийн түвшин өндөр байх магадлалтай. Инфляци 12 хувь буюу түүнээс дээш байна гэсэн тооцоог бид гаргасан. Гэхдээ орон сууцны үнийн өсөлт тогтворжино гэсэн хүлээлттэй байна.

Төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувиас илүү гаргахгүй нөхцлөөр 2014 оны улсын төсвийг баталсан. Засгийн газар шинээр өр тавьж, бонд гаргаж байгаа учраас улсын өрийн босгыг нэмэгдүүлэх асуудал тулгарч буй. Энэ нь төсвийн тогтвортой байдлын эсрэг юм. Бонд гаргасны өрийн төлбөрийг эхний ээлжинд 2018 онд төлөх болно. Тиймээс улсын өрийн менежментийн төлөвлөгөөг ойрын жилүүдэд гаргаж, эхлүүлэх шаардлагатай байна.

2013 онд хамгийн том банкуудын нэг болох Хадгаламж банкыг татан буулгасан. Банкны салбарын хувьд гэнэтийн цохилтод тэсвэрлэх дархлаа байхгүй. Чанаргүй зээлийн хэмжээ харьцангуй доогуур байгаа ч ялангуяа уул уурхай, худалдаа, хөдөө аж ахуй, барилгын салбарт төвлөрсөн эрсдэл өндөр байгаа юм. Худалдааны зээлийн хүүний түвшин 2013 онд дунджаар 18.7 хувьтай байв. 2014 онд 18 хувь байх болов уу хэмээн таамаглаж байна.

Валютын ханшид нөлөөлөх хүчин зүйлсэд томоохон өөрчлөлт орохгүй гэж бид харж байна. Энэ онд төгрөгийн

савалгаатай ханш хэвээр хадгалагдах магадлалтай. 2014 оны эцэс гэхэд ам.долларын ханш 1600 орчим төгрөг байх болов уу. Харин хамгийн тааруухан хувилбараар тооцвол 1920 төгрөг хүрэх болов уу гэж таамаглаж байна. ■

### 2014 онд голлох үзүүлэлтүүд ямар байх талаар “Мандал”-аас гаргасан төсөөлөл

Үзүүлэлтүүд	2013 (2013 оны 7-р сард хийсэн төсөөлөл)	2013 (гүйцэтгэл)	2014 (2013 оны 12-р сард гаргасан төсөөлөл)
ДНБ-ий өсөлт, хувиар	8	11.5 (Q3)	10
Инфляци, хувиар	10	11.1 (Nov)	12
Зээлийн хүүний түвшин, хувиар	18	18.6 (Nov)	18
Ам.доллар, төгрөг солих ханш, оны эцсээр	1700	1719 (10-р сарын 30)	1600
Чанаргүй зээлийн түвшин, хувиар	8	5.3 (10-р сар)	6

### Макро эдийн засгийн гол эрсдэл 2013 онд

Сөрөг үр дагавар	Өндөр	<ul style="list-style-type: none"> <li>Гадаад хөрөнгө оруулалтын гадагш чиглэсэн урсгал</li> </ul>	Оффис барилгын сегмент зэрэг барилгын салбарын зарим сегментийн талаарх санаа зовоосон асуудал	<ul style="list-style-type: none"> <li>Хувийн хэвшилд Засгийн газрын оролцоо асах их</li> <li>Төсвийн томоохон алдагдал</li> <li>Улсын өр өсөн нэмэгдэж буй</li> <li>Валютын ханшийн тогтворгүй байдал</li> <li>Өсөн нэмэгдэж буй инфляци</li> </ul>
	Дунд зэрэг	<ul style="list-style-type: none"> <li>БНХАУ-ын Засгийн газрын бодлого Монголд тааламжгүй байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Банкнүүд хөрвөх чадвар муудах</li> <li>Зээл авах боломж ховордох, эдийн засгийн эргэлт буурах</li> <li>Чанаргүй зээл нэмэгдэх, банкны салбар тогтворгүй болох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дэлхийн зах зээл дээр таваарын ханш унах</li> <li>Гадаад худалдааны алдагдал нэмэгдэх</li> <li>ОХУ-аас импортлодог түлшний үнэ нэмэгдэх</li> </ul>
Бага зэрэг	<ul style="list-style-type: none"> <li>Хөрш орнуудын халдварт өвчний тархалт</li> <li>Байгалийн гамшиг</li> </ul>			Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашралтай байгаа
	Бага зэрэг	Дунд зэрэг	Өндөр	
Болох магадлал				

# “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ТВ ХУВИЛБАР



Манай сэтгүүлийн үнэнч уншигч та бидний уран бүтээлийг мөн телевизээр үзэх боломжтой боллоо.

“Economy” ТВ студи улс оронд тулгарсан бүхий л асуудал, иргэн, бизнесмэнийг эмзэглүүлсэн аливаа сэдвийг цуврал нэвтрүүлэгтээ шууд хөндөн, шууд нэвтрүүлнэ. Тиймээс анхны бүтээл болох “Зантгар төр” нэвтрүүлэг олны хүртээл болгох гэж байна.

**“ШИНЭ ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ӨНГӨ”  
нэвтрүүлэг**

**Гарах телевиз: NTV**

**Гарах өдөр: Ням гариг, 2013.01.05**

**Гарах цаг: 18:00**

Уншигчдийн маань мэргэн дүгнэлт, үзэгчдийн минь онч үгс бидний бүтээлд том дэм болох билээ.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

# ЯАГААД УЛААН БУУДАЙ ИМПОРТЛОХОД ХҮРЭВ

С.ЗАЯА

“Атрын-III” аян хэрэгжсэнээс хойш манай улс газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах түвшинд хүрээд байв. Өөрөөр хэлбэл, 2008 оноос хэрэгжсэн уг аян уналтад ороод байсан энэ салбарт сэргэлт авчирсан. Улмаар цаашид эрчимтэй хөгжих боломжийг бий болгоод байв. Хоёр хөршөөсөө төмс хүнсний ногоо, гурил импортолж байсан бид эх орны үржил шимт хөрсөнд ургасан тариа будаа хэрэглэж эхэлсэн. Бүр тарьсан улаан буудайгаар гурилынхаа хэрэгцээг хангаад зогсохгүй 100 мянган тонныг экспортлох тухай ч ярьж байлаа. Харин одоо бид

100 хүртэл мянган тонн буудай импортлох шаардлагатай болчихов. Улсын хэмжээнд 2013 онд 400 мянган тонн улаан буудай хурааж авахаар төлөвлөж байсан ч цаг агаарын таагүй нөхцөл болон тариалан эрхлэгчдийн техник зэргээс шалтгаалан 370 орчим мянган тонныг хураан авчээ. Баримт сөхөхөд, манай улс 1990 оноос хойш жилд 75-125 мянган тонн буудай хурааж авч байсан бол сүүлийн гурван жилд 300-400 мянган тоннод хүрч суга өссөн нь аяны ач тус байв. Улмаар Тариалан эрхлэлтийг дэмжих санд жил бүр дотоодын ургацаас 200 орчим мянган тонн буудайн нөөц бүрдүүлж байж. Харин одоогийн нөхцөл байдалд ямар хүчин зүйлс нөлөөлөв.

## “Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөр” тушаа болсон уу

“Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах дэд хөтөлбөр” хэрэгжүүлэх хүрээнд 2013 онд гурилын үнийг кг тутмыг нь 550 төгрөгт тогтворжуулах бодлого барьсан. Үүнээс өмнөх дөрвөн жилд манайх дотоодынхоо гурилын хэрэгцээг хангаж, алслагдсан аймгуудад бага хэмжээгээр гурил импортоор авч байжээ. Гэтэл гурилын үнийг инфляциас үл хамааран нэг тоонд тогтоон барьсан нь импортын хэрэглээг бүрэн зогсооход хүргэсэн байна. Өөрөөр хэлбэл, импортын гурил үнэтэй байсан учир Тариалан эрхлэлтийг дэмжих сан нөөцөөсөө гурил үйлдвэрлэж эхэлж. Үүний гор энэ жил гарч, тус сан ердөө 25-хан мянган тонн буудайн нөөцтэй болсон байна. 2013 онд авсан ургацаар 190 орчим мянган тонн гурил үйлдвэрлэхээр байгаа аж. Ойрын жилүүдэд улсын хэмжээнд 187.7 мянган тонн гурил хэрэглэдэг байсан бол энэ онд 267 орчим мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн хэрэглэх тооцоо гарчээ. Валютын ханшийн өсөлттэй холбоотойгоор энэ төрлийн бүтээгдэхүүн импортоор орж ирэх нь багассан учир хэрэгцээг мөн л дотоодоос хангахаар болжээ. Тиймээс 100 хүртэл мянган тонн улаан буудайг импортоор авахаас өөр аргагүй гэх мэдээллийг салбарын яамны удирдлагууд хэлж байна. Энэ нь гурилын үнийг өсгөхгүй ▶



▶ байх арга хэмээн тэд тайлбарлаж сууна. Импортлосон буудайгаа Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нөөцөд авахаасаа илүү дотоодын үйлдвэрүүдэд өгөхөөр төлөвлөөд буйгаа ч дуулгав.

### Бага үнээр буудай худалдаж авсан нь ургацад нөлөөлжээ


2010, 2011 онд тариалан эрхлэгчдээс тонн улаан буудайг 350 мянган төгрөгөөр худалдаж авч байсан. Харин 2012 онд тонн тутмыг нь 280 мянган төгрөгөөр худалдаж авсан нь тариалан эрхлэгчдийг рапс буюу тосны ургамал тариалахад хүргэжээ. Өөрөөр хэлбэл, газар дээрээсээ худалдаалагддаг, тариалалтын зардал хямд төсөр энэ ургамлыг тариалах нь тэдэнд ашигтай байсан байна. 2013 онд улаан буудай тариалахаар тооцоолж байсан талбай 20 мянган га-гаар багасчээ. Манай улс сүүлийн жилүүдэд тосны ургамлыг 25-30 мянган га-д тариалж байв. Гэтэл өнгөрсөн онд рапс тариалах талбай 79 мянган га болж нэмэгдсэн байна. Газрын хөрсийг сүйтгэдэг байгаль орчинд халтай тул өмнөд хөрш энэ ургамлыг тариалахаа бараг зогсоосон аж. Тэд манай тариалсан рапсыг газар дээрээс нь тонн тутмыг нь 700-800 мянган төгрөгөөр авчээ. Энэ нь улаан буудайн үнээс даруй нэг дахин илүү юм. Үнэ хүрэх, эрэлттэй бүтээгдэхүүн сонгох нь бизнесийн алтан зарчим. Эл зарчмаар тариалан эрхлэгчид улаан буудайн талбайдаа рапс тарьсан учраас тэднийг буруутгах аргагүй. Рапсыг таримлын сэлгээнд байлгах ёстой ч тариаланчид үнэ хүрэх ургамал руу хошуурсан нь төрийн бодлого тэдэн рүү чиглээгүйг илтгэнэ. Хятад үрээр тарьж буй рапс манайд ашиггүйн дээр газрыг үржил шимгүй болгодог аж. Гэсэн ч тосны ургамлыг салбар хариуцсан яамнаас зохицуулж чадалгүй өнөөг хүрчээ. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас нийт газар тариалангийн талбайн 15 хувьд рапс тарьж болно гэж заажээ. 2013 онд манай улс 42 мянган тонн рапс хураан авсан нь нийт талбайн

19.5 хувь юм байна. Тосны ургамлыг нэг талбайд дөрвөн жилийн дараа эргэж тарихаар сэлгээнд оруулах нь зохимжтой байдаг аж. Тиймээс салбарын яам хил гаалиар орж ирж буй хятад үрийн эл ургамлыг аль болох тариалуулахгүй байх бодлого барьж эхэлжээ. Өнгөрсөн оноос зарим тариалан эрхлэгч Герман сортын тосны ургамал тариалсан гэх. Энэ үрийг Монголын хөрсөнд тариалах боломжтой нь хураан авсан ургацаас илт мэдрэгдсэн байна. Цаашид дотооддоо ургамлын тосны хэрэгцээг хангахуйц үйлдвэр ашиглалтад ороход түүхий эд нь болох аж.


### Харамч хүн хоёр төлнө

Буудайг тариалан эрхлэгчдээс тонн тутмыг нь 2009-2011 оныхоос 100 орчим мянган төгрөгөөр бууруулж авсан. Энэ нь 40 сая ам.долларыг хий дэмий салхинд хийсгэхэд хүргэв. Улаан буудайг төмөр замаар тээвэрлэж авах учраас ОХУ, Казахстан хоёроос авах гарц буй аж. Харин аль боомтоор хэчнээн тонноор нь оруулж ирэхийг Засгийн газрын журмаар зохицуулах юм. Хүнсний тухай болон Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу сайн чанарын буудай импортлоно гэж буй ч III зэргийн буудай авах бололтой. Энэ нь хүнсний ангилал бөгөөд 100 мянган тонн буудай монголчуудын гурилын 3-4 сарын хэрэглээ аж. ОХУ-ын зах зээл дээр тонн буудай 280 ам.доллар үнэтэй байгаа нь 400 гаруй мянган төгрөг гэсэн үг. 100 мянган тонн буудай импортлоход гааль болон НӨАТ-ын татвараас чөлөөлөх хуулийн төсөл батлагдвал бид 40 сая ам.долларын буудай оруулж ирнэ. Уг нь тариалан эрхлэгчдэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг хасаагүй бол өнгөрсөн жил хурааж авах буудайн хэмжээнд нөлөөлөхгүй байх учиртай. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нөөц ч өмнөх жилийнхээс дундрахгүй учир импортоор буудай авах асуудал ийн яригдахгүй байсан биз ээ. Тариаланчдад урамшууллыг нь хуучин хэвээр олгосон бол дээр дурдсан хэмжээний үрэлгэн зардал гарахгүй байв. ■

Импортоор орж ирсэн гурилын хэмжээ (мянган тонн)



Улаан буудайн нөөц (мянган тонн)



Эх сурвалж: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам




## ҮЛ ХӨДЛӨХ

# ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНИЙН ХӨӨСРӨЛ

Р.ГАНТУЛГА

Үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлийн асуудал дахин сөхөгдөх болов. Сүүлийн үед Dow Jones Industrial Average индекс нь хамгийн өндөр үзүүлэлттэй болоод байна. Алдагдалтай ажиллаж буй технологийн Twitter компани хөрөнгийн зах зээлд анх удаа хувьцаа гаргав. 2008 оноос хойш нүдний гэм болсон өрийн үнийн дүнг ашиглан компаниуд хоорондоо нэгдэж, зарим компанийг худалдан авч байна. Манхэттен дэх пентхаус орон сууцны үнэ маш ихээр өсч, 50 сая ам.доллар давжээ. Мөн Английн зураач Францис Беконь гурамсан уран зураг 142.4 сая ам.доллараар зарагдсан байх жишээтэй. АНУ-ын Илийн их сургуулийн эдийн засгийн ухааны профессор Роберт Шиллер 1990 оны сүүлээр болсон хувьцааны үнийн хөөсрөлийг үнэн зөв тодорхойлсон. Мөн 2000-аад оны үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлийг олж харж чадсан нэгэн. Тэрбээр АНУ-ын толгой эргэм хувьцааны үнэлгээний талаар санаа зовж буйгаа илэрхийлсэн байна.

Дээрх жишээнүүд нь чинээлэг хөрөнгө оруулагчдын итгэл нэлээд сэргэж байгааг харуулж буй. Гэхдээ тэдний үйлдэл зөв эсэх талаар асуулт гарч ирнэ. Тодорхой нөхцөл байдалд хурдацтай нэмэгдэж буй хөрөнгийн үнийг зөвтгөх боломжтой. Шинэ салбарууд томоохон компаниудыг бий болгодог. Тухайлбал, Microsoft, Apple, Google гэх мэт. Мөн аливаа



улс, орон эдийн засгийн бодлогоо эрс өөрчилж эдийн засаг нь хурдацтай өсдөг байна. Тухайлбал, 60-аад оны Японы эдийн засгийн өсөлт, 90-ээд оны Хятадын өсөлтийг дурдаж болох юм. Тэгвэл үнийн хөөсрөлөөс хувьцааны үнэ өсөх үе (bull market)-ийг хэрхэн ялгаж, мэдэх боломжтой юм бол?

Роберт Шиллер “Үнийн хөөсрөл нь сэтгэл зүйтэй холбоотой эдийн засгийн гоц үзэгдэл. Яг л мэдрэлийн өвчинтэй адилхан. Энэ нь хэт өөдрөг үзэл, мэдээллийн хэрэгслийн хэт оролцоо, мөн үнийн хөөсрөлд автаж үзээгүй хүмүүст төрдөг харамсалтай мэдрэмж зэргээр илэрдэг” гэжээ. Зээлийн хэмжээ данхайхын хэрээр үнийн хөөсрөл улам томордог. Энэ ойлголтыг тайлбарлах бодитой тодорхойлолт гаргахад хүндрэлтэй аж. Хөрөнгийн менежментийн GMO группын хувьд хөөсрөл гэдэг нь бодит

үнийн хандлагаасаа илүү үнэтэй, хоёроос дээш стандарт хэлбэлзэл бүхий хөрөнгийн үнэ нэмэгдэхийг хэлдэг аж.

GMO нь уг стандартыг ашиглан 1720-2010 оны хоорондох үнийн хөөсрөлийн 330 удаагийн тохиолдлыг олж тогтоожээ. Сүүлийн хэдэн арван жилд давтамж нь огцом нэмэгдэх болсон байна. Доорх хүснэгтийг харна уу.

Энэ нь зарим талаас хөөсрөлийн үеийг задлан шинжлэх илүү олон зах зээл байгаатай холбоотой байж болох юм. Мөн нөгөө талаас 1970-аад онд валютын ханш солих тогтсон ханшийг барьдаг байсан “Бреттон Вүүдс”-ийн систем нурж унасан. Үүнээс шалтгаалан дэлхийн хөрөнгийн урсгалд томоохон өөрчлөлт гарсантай ч холбоотой байж болох. Хөрөнгө оруулагчид дараа, дараачийн том ▶

► ангийн эрэлд мордож, дэлхийгээр хэрэн тэнүүчилдэг. Энэ нь ч илүү их хөөсрөлийг бий болгоход нөлөөлдөг гэхэд гайхаад байх зүйлгүй л болов уу.

Үнийн хөөсрөл байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх гэж олон эдийн засагч хичээсээр ирсэн. Учир нь хөөсрөл нь үр ашигтай зах зээлийн санаа, санаачилгатай хослохдоо маш тааруухан байдагтай холбоотой. Хэрэв тухайн хөрөнгө бодит бус үнэлгээтэй байгаа нь тодорхой л юм бол ухаалаг хөрөнгө оруулагчид яагаад давуу талаа ашиглан, зарчихаж болдоггүй юм бол? ГМО-ийн Эдвард Канцлер “Үнийн хөөсрөлөөс ашиг гаргаж авах нь амаргүй зүйл болохыг хөрөнгө оруулагчид мэдэх боломжтой” хэмээн учирласан. Үнийн хөөсрөл хөрөнгө оруулагчдын тооцоолсноос ч илүү урт үлгэлжилж болдог. Харин бусдаасаа өөрөөр сэтгэдэг зарим хөрөнгө оруулагч 1990 оны сүүлээр болсон интернэтийн оргил үед ихээхэн зардал хаяж байв. Тухайн үеийн хөөсрөлийн шийдэл нь үнийн огцом уналт болон удаан хугацааны зогсонги байдал байх эсэхийг тэд мэдэхгүй байсан. Бодит утгаараа инфляци үнэд сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал, 70-аад онд Их Британийн орон сууцын зах зээлд болсон үйл явдлыг дурдаж болох юм.

Лондоны эдийн засгийн сургуулийн профессор Димитрий Ваяанос, доктор Пол Вүүли нар үнийн хөөсрөлийг агентлаг, зуучтай холбон тайлбарлажээ. Хөрөнгө оруулагчид өөрсдөө шууд хувьцаа худалдаж авахгүй нь тодорхой. Харин брокер, дилерт мөнгө төлж, тэднээр дамжуулан худалдан авдаг. Хөрөнгө оруулагчид өмнө нь амжилт гаргаж байсан, туршлагатай менежерээр зуучлуулахыг эрхэмлэдэг. Шинэ үйлчлүүлэгчээсээ мөнгө авсан менежер өөрт таалагдсан, цаашид ашгаа өгнө гэж найдсан хувьцаагаа худалдан авна. Энэ нь ч 1990 оны сүүл үеэр технологийн санд ихээхэн мөнгийг хуримтлуулсан байна. Тэдний дэмжиж сонгосон хувьцаа тооцоолж байснаас ч илүү өндөр ашгаа өгсөн нь бий.


Хөрөнгийн үнийн хөөсрөлд

өөрийгөө бэхжүүлэх элемент гэж байдаг. Ихэнх хөрөнгийг банкнаас зээлсэн мөнгөөр худалдан авдаг байна. Хөрөнгийн үнэ өсөхөд банкууд мөнгөө бүр ч итгэлтэй зээлдүүлж эхэлдэг. Ийнхүү зээл авах боломж нэмэгдэх нь зээлдэгчид илүү их үнэ төлөх боломжтой болно гэсэн үг. Эсрэгээрээ банкууд мөнгө зээлэх боломжгүйдвэл хөрөнгийн үнэ буурдаг.

Олон хүн өнөөгийн мөнгөний бодлогыг үнийн хөөсрөл бий болгоход түлхэц болох магадлалтай гэж итгэж байгаа аж. Ихэнх хөгжингүй орнууд одоогийн байдлаар нэрлэсэн бодлогын хүүгээ тэг хувьд ойртуулсан байна. Төвбанкууд эдийн засагтаа шинээр мөнгө нийлүүлж, уламжлалт бус мөнгөний бодлого баримтлах хэлбэрээр бонд худалдан авах болсон. Үүний зорилго нь хамгийн бага эрсдэлтэй хөрөнгөөс олох өгөөжийг бууруулах. Ингэснээр хөрөнгө оруулагчдыг илүү эрсдэлтэй хөрөнгө худалдан авахыг урамшуулан дэмжих. Компаниудад зориулсан санхүүгийн зардлыг бууруулж, эдийн засгийн итгэлийг нэмэгдүүлэх. Ингэхдээ хөрөнгө нэмэгдэхийн хэрээр илүү зарцуулдаг гэсэн онол (wealth effect)-оор дамжуулан хийнэ.

Бодлогын хүүний доогуур ханш нь эрсдэлтэй хөрөнгө илүү өгөөжтэй гэдэгт зарим хөрөнгө оруулагчдыг итгүүлэх зорилготой байж болох. Аль нэг банк хүүгээ бууруулж, ирээдүйн бэлэн мөнгөний үнэ цэнэ буурна гэсэн хандлага үзүүлж болно. Энэ нь өнөөгийн хөрөнгийн үнэ цэнийг улам нэмэгдүүлж буй хэрэг. Гэхдээ бусад зүйл ч гэсэн тэнцвэртэй байх шаардлагатай гэсэн нөхцөлтэйгээр. Олон төвбанк уламжлалт бус мөнгөний бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Учир нь эдийн засгийн хэтийн төлөв тааруухан байх болов уу хэмээн санаа зовсных. Хэрэв энэ нь үнэн бол хөрөнгө оруулагчид цаашид ногдол ашиг, түрээс зэрэг хөрөнгөөс орж ирэх бэлэн мөнгөний урсгалын хэмжээгээ бууруулж тооцох хэрэгтэй юм.

Үүний уршгаар зах зээлд хоёр төрлийн эрсдэл учирч болно. Нэгдүгээрт, хөрөнгөөс олох орлого нь хөрөнгө оруулагчдын хүсэн хүлээсэн



шиг түргэн хугацаанд нэмэгдэхгүй. Хоёрдугаарт, хэрэв мөнгөний бодлого дахин өөрчлөгдвөл хөрөнгийн үнэлгээ огцом унах аюултай. Английн Төвбанк санхүүгийн тогтвортой байдлын талаар сүүлд гаргасан тайландаа мөнгөний бодлогын нөлөө хэрээс хэтэрсэн гэж дурдсан байна. Уг тайланд “Шинээр гарч ирж буй орнууд руу урсаж буй хөрөнгийн том урсгал тухайн орнуудын зээлийн ханшийг нь хурдацтай нэмэгдүүлж байна” гэжээ. Өнгөрсөн зун АНУ-ын Холбооны нөөцийн банк сар бүрийн бонд худалдан авалтаа цаашид хумих талаар ярьж эхлэхэд шинэхэн зах зээлүүд яаж ганхаж байлаа даа.

2008 болон 2009 оны эхэн үед олон орны эдийн засаг хямарч эхэлсэн. Харин сүүлийн үед харьцангуй сэргэж байгаа нь ажиглагдах болов. Өнгөрсөн 15 жилийн хугацаанд хөрөнгө оруулагчдын хүртсэн ашиг тийм ч сайн биш. Гэхдээ өнгөрсөн үед хэт өндөр үнэлгээтэй зах зээл цөөнгүй байв. Роберт Шиллер АНУ-ын хувьцааг тодорхой давтамжаар тохируулсан үнэ, ашгийн 25 гэсэн харьцаатайгаар арилждаг гэжээ. Энэ нь түүхэн дундаж болох 16.5-аас нэлээд өндөр. Гэвч 1929 болон 2000 онд хүрч байсан оргил хэмжээнээс доогуур үзүүлэлт юм. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш ДНБ-тэй холбоотойгоор компанийн ашиг, орлого хамгийн өндөр түвшиндээ хүрсэн. Гэхдээ цаашид өсөлтийн хандлага тааруухан байх магадлалтай аж.

Гэхдээ Роберт Шиллер АНУ-ын хувьцааны зах зээлд хөөсрөл бий болсон гэдгийг албан ёсоор хараахан ►

▶ зарлаагүй байна. 1990 оны сүүл үеэр хувьцааны үнэ өсч байсан шиг тийм гайхалтай зүйл тохиолдож байгаагүй юм. Хамтарсан сангууд руу чиглэсэн цэвэр урсгал дөнгөж өнгөрсөн оноос хойш нааштай эргээд байна.

Зарим эдийн засагч Засгийн газрын бондыг хүртэл хөөсрөл гэсэн ангилалд хамруулж авч үздэг. 2012 онд зарим зах зээлд үнэт цаасны өгөөж хамгийн доод түвшиндээ хүрсэн. Өмнө нь өгөөж нь хоёроос бага хувьтай бонд худалдан авбал ихээхэн алдагдал дагуулдаг байв. Гэхдээ өрийн зах зээл бусад хэмжүүрээр бол хөөсөрсөн гэж харагддаггүй байна. Бондын хамгийн том худалдан авагч нь Төвбанк. Ганцхан асуудал нь Төвбанк бондын

худалдан авалтаа сулруулах үед энэ нь зах зээлд эмгээр нөлөөлөх магадлалтай байдаг.

Шинэ Зеланд, Канад болон Австралид үл хөдлөх хөрөнгийн үнэ хөөсрөлтэй байгааг The Economist сэтгүүлийн орон сууцны үнийн индикатораас харуулж байна. Мөн GMO нь Их Британи болон Шведийн орон сууцны зах зээлд үнийн хөөсрөл бий болсон гэж үзэж байгаа аж. Хонконгийн хувьд 2012 оноос хойш хөрөнгийн үнэ бараг 20 хувиар нэмэгдээд байна.

Өнгөрсөн онд Японы хувьцаа иенийн нөхцлөөр 51 хувиар өссөн. Тус улсын хувьд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд эдийн засаг нь олигтой өссөнгүй. Харин өнгөрсөн

оноос харьцангуй сэргэх болжээ. Мөн хугацаанд Венесуэлийн хувьцаа тав дахин, ам.долларын нөхцлөөр 273 хувиар өсчээ. Гэвч энэ нь олон улсын хөрөнгө оруулагчдын хувьд төдийлэн ач холбогдолтой биш байсан бололтой.

Хөгжиж буй орнуудын хувьцааны өсөлтийг хөгжингүй орнуудын түвшинд авчраад шинжвэл тухайн өндөр ханш ямар ч утгагүй болж хувирна. Түүхийн туршид чинээлэг хүмүүс доод зиндааныхан нь авч хүчрэхгүй тийм тансаг бараа, бүтээгдэхүүн хэрэглэж, түүгээрээ гайхуулан, өөрсдийн байр сууриа илэрхийлэх дуртай байв, одоо ч хэвээр. Хуучны алдарт зураачийн уран бүтээл Манхетний пентхаусыг сэтгэл татам, тансаг орон сууц болгох чадалтай ажээ. ■

## ҮЗЭЛ БОДОЛ

# ТӨГРӨГИЙН СУЛРАЛЫН ЦААД УЧИР



Ж.ГӨЛГӨӨ (ДОКТОР)

Монголын үндэсний валютын ханшийн огцом уналт өнгөрсөн оны сүүлийн хагасаас эхэлсэн. Үүнийг олонхи судлаач, улс төрчид экспортын хийгээд гадаадын хөрөнгө оруулалтын бууралттай холбон тайлбарлаж байгаа. Эдгээр хүчин зүйл зохих хэмжээнд нөлөөлж буйг үгүйсгэхгүй. Гэхдээ төгрөгийн сулралын далд хэрнээ үндсэн шалтгаан нь өөр юм.

Тэрхүү хүчин зүйл нь сүүлийн жилүүдийн эдийн засгийн бодлоготой, тэр дундаа үндэсний үйлдвэрлэлд үзүүлж буй дэмжлэгтэй холбоотой. Тайлбарлая. Зөвхөн хонины ноосны урамшуулалд гэхэд л 2012 онд 20 тэрбум, өнгөрөгч онд 32 тэрбум

төгрөгийг зарцуулав. Бод малын шир тутамд 15, богийн арьсанд 3000, тонн улаан буудайд 100 мянган төгрөгийг тус тусад нь урамшуулал болгоно гэхчлэнгээр татаасын цуваа үргэлжилнэ. Эдгээр “урамшуулал” үндэсний үйлдвэрлэлийн өртөг зардлыг хаа нэгтээ, эсвэл бэлтгэн нийлүүлэлтийн, эс бөгөөс үйлдвэрлэлийн шатанд өсгөж буй. Өөрөөр хэлбэл, тэр хэмжээгээр үндэсний бүтээмж буурч олон улсынхтай харьцуулахад доошилж байгаа гэсэн үг. Өртөг зардал сүүлийн хоёр жилд 20 хувиар нэмэгдэв. Энэ хэмжээгээр өрсөлдөх чадвар уналаа гэхэд болно. ▶



► Энд нэг нэрмээс хүчин зүйл нь хөнгөлөлттэй зээл. Чингис бондоос гэхэд л дөрвөн салбарт 170 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл өгсөн. Тэр нь ноос ноолуур, оёмол сүлжмэл, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүлэмжийн аж. Энэ нь хөрөнгө үйлдвэрлэлийн хүчин зүйл болоод эргээд үр өгөөжөө өгтөл наанадаж 3-5 жил хэрэгтэй. Тэр болтол хүү, үндсэн өр нь төлөгдөж, улмаар үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлсээр байх болно. Зээл авсан зарим нь алдагдалд орвол өр төлбөр нь татвар төлөгчдийн нуруун дээр бууна.

Японы иенийн америк доллартай харьцах ханш II дайны дараа 360 байсан. 1970-аад оны сүүлээр 240, эдүгээ 100 орчим болсон байдаг. Валютын интервенци, мөнгөний бодлогоор ханшийн хэлбэлзлийг богино хугацаанд зохих хэмжээнд зохицуулж болдог. Гэвч урт хугацаанд үндэсний хөдөлмөрийн бүтээмж л ханшийг тодорхойлдог жишээ энэ. Энд анхаарах нэг зүйл бол экспортын орлогын өсөлт ч, бүр эдийн засгийн өсөлт ч тэр хэмжээгээрээ ханшийн урт хугацааны хөдөлгөөнд нөлөөлж чаддаггүй. Өнгөрсөн онд хэрэг дээрээ экспортын орлого өмнөх оныхоосоо 15 орчим хувиар л буурсан. Гэтэл валютын нөөцөөс худалдсаар байтал, валютаар босгосон бондоос эдийн засаг руу шахсаар байтал

төгрөгийн ханш 30 шахам хувиар унав. Шалтгаан нь чухамхүү үйлдвэрлэлийн зардал өссөнөөс үүдэлтэй.

Эдийн засгийн агшилтыг сааруулахын тулд гүйлгээнд оруулсан 2,7 их наяд төгрөгийн бараа үйлчилгээний материаллаг баталгааг Чингисбондүндсэнд нь хангаж байлаа. Гүйлгээн дэх мөнгөний хэмжээний онол талаас нь үзвэл инфляцийг ч, ханшны уналтыг ч төдийлөн хөөрөгдөх ёсгүй. Гэхдээ мөнгөний тэлэх бодлогыг даруй зогсоохгүй бол цаашдаа жолоодлогогүй инфляци руу хөтөлнө. Эдийн засгийн эргэлтэд үйлчлэх мөнгөний тоо (M2) хэмжээнээсээ хэтэрмэгц худалдан авах чадварыг унагадаг. Үүний нэг адил зээлийн зохиомол хүү ч инфляцийг хөхиүлнэ. Орон сууцны зээлийн хүүг найман хувьд оруулмагц орон сууцны үнэ огцом өсч буй. Энэ эрэлт өссөнийх үү, зээлийн өртгийн нуугдмал хэсгийн илрэл үү гэдгийг ялгахад хэцүү.

Эрх баригчдын олонх нь уг эдийн засгийн агшилтыг дэлхийн зах зээлийн хямрал руу чихэж буй. Гэтэл манай гадаад худалдааны 85 орчим хувь нь хаяа нийлсэн хоёр хөршид ноогдож буй. Гол түнш болох БНХАУ-ын эдийн засаг долоон хувиас давж өссөн хэвээр

байна. Нүүрс, жонш зэрэг эрдсээс бусад манай бүтээгдэхүүний экспорт үнийн дүнгээрээ өмнөх жилүүдийнхээс төдий л буураагүй. Эдгээр баримт нь асуудлын гогцоо үндэсний үйлдвэрлэлийн хүрээнд байгааг бас л хэлээд буй хэрэг.

Эдийн засаг жам ёсны өсөлттэй үед үнэ 2-3 хувиар л ахидаг. Гэтэл ДНБ 11 хувиар нэмэгдэвч бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийлмэл үзүүлэлтээрээ 10 хувиас буурахгүй төлөвтэй байв. Энэ нь тоон ахицтай бодит өсөлтгүй, инфляцийн "хөөс"-нд саармагжиж буйг харуулж байна. Эдийн засгийг урт хугацаанд эрүүлжүүлэх жор нь ханшийг бууруулахдаа биш юм. Харин нь үндэсний бүтээмжийг дээшлүүлэхэд оршиж байна гэсэн үг.

Дотооддоо үйлдвэрлэл явуулах нэг хэрэг, гэхдээ ямар өртөг зардлаар вэ гэдэг түүнээс ч чухал асуудал. Үлгэрлэвээс гадицыг Хөвсгөл нуурын савд ч тариалж болно, гэхдээ хүлэмжид ургуулсан энэ жимс, Индонезийн Балигийнхтэй өрсөлдөж чадах уу гэдэг л гол нь. Жишээ нь ноолуурын салбарыг бараг сүүлийн 20 жилийн турш экспортын татварын, бэлтгэн нийлүүлэлтийн бодлогоор дэмжиж ирсэн. Энэ салбарт ахиц дэвшил гарч буйг үгүйсгэхгүй. Чингис бондоос ч аанай л 68,8 сая ам.доллар зарцуулж байгаа. Төрөлхийн сульдаатай хүүхдийг насан туршид нь эмчлүүлэх шаардлага байдаг. Үүний адил анхнаасаа үр ашиг доогуур салбаруудыг дэмжих тусам татвар төлөгчдийн нуруун дээрх дарамт өснө. Ноолуурын салбар дахь гадаадын хөрөнгийн оролцоо үндсэндээ Монголоос дайжаад явчихлаа. Энэ нь олон улсын хэмжээнд уг салбар өрсөлдөх чадваргүйг нь ойлгосны илрэл болов уу. Зах зээлийн эдийн засгийн зарчим нь өртөг зардалд суурилсан өрсөлдөөн, шалгарал гэдгийг бүү март. Ажлын байр бий болгох, үндэсний үйлдвэрлэл хийгээд экспортыг дэмжих нь чухал хэдий ч үр ашгийн шалгууртай харьцуулахад хоёрдох эрэмбийн асуудал болой. ■

## ТЕХНОЛОГИ

# ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕРИЙГ ХЭРХЭН СОНГОХ ВЭ

Б.БЯМБАДОРЖ

Өнөөдрийн бидний амьдралын чухал нэгэн хэсэг бол зөөврийн компьютер буюу “нөөтбүүк” юм. Шинэ компьютер авахад хэтэрхий олон сонголт байгаа мэт санагдах үе байдаг. Өнөөдөр netbook, ultrabook зэрэг хэд хэдэн төрлийн зөөврийн компьютер худалдаанд гарснаас сонгож болох. Гэхдээ өөрт таарсан, зөв компьютерийг сонгох нь хэцүү байх талтай.

Компьютер худалдаж авахдаа хурд, хүчин чадлын үзүүлэлтээс гадна, жин, дулаан ялгаруулалт, дуу чимээ, дизайн гэх бусад хүчин зүйлүүдийг тооц. Тэгвэл худалдан авалтаа 100 хувь сэтгэл хангалуун байх болно. Мөн тухайн компьютерийг ямар зориулалтаар ашиглахаа байнга санаарай.

Сүүлийн хэдэн жилд нөөтбүүкний хэмжээ хүчин чадал их ялгаатай болж, олон төрөл болсон. Хамгийн энгийн жишээ нь Intel компанийн зөөврийн компьютерийн маркетингийн нэр болох ultrabook юм. Тус компьютерүүд нь жин, хэмжээ нь тодорхой хязгаартай байдаг. Уг ultrabook төрлийн компьютер нь ихэвчлэн өндөр хүчин чадалтай, жижиг хэмжээтэй. Овор хэмжээнээс гадна netbook нь хямдхан, бага хүчин чадалтай, хөнгөн жинтэйгээрээ ялгардаг. Гэхдээ ихэнх тохиолдолд netbook нь зөвхөн бичиг баримт боловсруулж, интернетэд холбогдох хэмжээний л хүчин чадалтай байдаг.

## HDD

“Hard Disk Drive” (HDD) нь тус компьютер хэр их мэдээлэл хадгалж болохыг заадаг.

HDD нь гигабайт (GB) нэгжээр хэмжигддэг ба ихэвчлэн 100GB – 1,000GB хэмжээтэй байдаг. Тухайн хэрэглэгчид их хэмжээний кино, зураг, дууны сан байдаггүй л бол HDD хэмжээ 500GB –аас илүү хэмжээ хэрэггүй.

Сүүлийн үеийн компьютерууд шинэ төрлийн хадгалах системтэй үйлдвэрлэгдэж байгаа нь “Solid State Drive” (SSD) юм. Энэхүү мэдээлэл хадгалах диск нь ирээдүйд HDD –г орлож эхэлнэ. Гэсэн ч өнөөгийн байдлаар нэгж үнэ нь HDD –тай харьцуулахад илүү үнэтэй байна. Жишээлбэл



128 GB SSD –ий үнэ 1,000 GB HDD –тэй дүйцэж байгаа юм. Гэхдээ SSD –ийн давуу тал юу вэ?

SSD нь HDD –тэй харьцуулахад хөдөлдөг механик эд анги байхгүй. Тиймээс гэнэтийн доргилт, чичиргээнд таны материалыг найдвартай хадгалж чадна. Хуучин HDD –тэй харьцуулахад чимээ багатай, хөнгөн жинтэй. Мөн мэдээлэл устгах аюул бараг үгүй бөгөөд бичих, унших хурд нь илүү юм.

Зарим компьютер SSD/HDD “холимог” байдаг. Түүнчлэн бага хэмжээний SSD –г зөвхөн компьютерийг хурдан болгоход ашиглана. HDD хэсгийг нь мэдээллийн “агуулах” болгож ашигладаг.

## CPU

“Central Processing Unit” (CPU) буюу процессор нь гигагерц (GHz) нэгжээр хэмжигдэнэ. Мөн тухайн компьютер ямар нэг ажлыг хэр хурдан хийх вэ гэдгийг тодорхойлдог.

Intel компанийн процессор нийлүүлэлт нь зах зээлийн нийт 80 хувийг эзэмшдэг. Тус компанийн сүүлийн үеийн Core i3, i5, i7 процессорууд нь хүчин чадлын гурван түвшнийг илэрхийлдэг байна. Core i3 нь бага хүчин чадалтай, хамгийн бага цахилгаан зарцуулалттай ▶

▶ процессор. Харин Core i7 нь өндөр хүчин чадалтай юм. Иймд Core i7 процессор нь ихэвчлэн хамгийн үнэтэй нь байдаг.

Хэрэв хэрэглэгч нь энгийн бичиг цаасны материал боловсруулж, интернэт хэрэглэхээс гадна өндөр хүчин чадал шаардах ажил хийхгүй бол Core i3 процессор нь зөв сонголт юм.

Процессорын хүчин чадал ихсэх тусам компьютерийнх нь үнэ өснө гэдгийг байнга санаарай.

## GPU

“Graphics processing unit” (GPU) буюу график процессор нь тухайн компьютерийн дүрс гаргах чадварыг илэрхийлдэг.

Бүх зөөврийн компьютер дагалдах GPU –тай байдаг. Тэдний хүчин чадал энгийн бөгөөд кино, YouTube үзэхэд хангалттай. Хэрэв хэрэглэгч нь видео бичлэг монтажлагч, график дизайнер, эсвэл өндөр дүрслэх чадвар шаардсан компьютер тоглоом тоглох санаатай бол сайн GPU зайлшгүй шаардлагатай.

Өнөөдөр компьютерийн график дүрслэлийн бизнесийг Intel, NVidia, AMD гэх гурван компани тэргүүлж байна. Intel нь бага хүчин чадалтай, эрчим хүчний хэмнэлттэй GPU үйлдвэрлэдэг. NVidia, AMD хоёр нь өндөр хүчин чадалтай график процессоруудын хүрээнд өрсөлдөгчид юм.

## RAM

“Random access memory” (RAM) нь тухайн компьютер хэдэн үйлдэл зэрэг хийж чадахыг харуулна.

Тухайлбал дуу сонсож, интернетээр ном унших нь хоёр “үйлдэл” зэрэг хийж байгаа гэж ойлгож болно.

RAM нь ямар ч компьютерт ойролцоогоор 1GB – 8GB хэмжээтэй байдаг. Хэрэв компьютерийн ажиллагаа нь бичиг цаасны ажлаар хязгаарлагдах бол 2GB RAM хангалттай. Харин видео бичлэг монатажлах, график дизайн хийх, эсвэл тоглоом тоглох бол 4GB хэмжээтэй RAM хэрэглэгчийн хэргцээг хангана. Энэ үед кино үзэж, дуу сонсон хэд хэдэн давхар “цонх” нээх бол 4GB –аас дээш RAM нь илүү зохистой.

RAM хэмжээ нэмэгдэхэд компьютерийн үнэ мөн л нэмэгддэг.

## Бусад анхаарах зүйлс

Зөөврийн компьютеруудын доторх эд анги нь ерөнхийдөө адилхан байдаг. Тэднийг ялгаруулж харуулах ганц зүйл нь дизайн юм. Мэдээж дизайныг хэрэглэгч өөрөө сонгох ба энэ нь худалдан авалтад нөлөөлөх томоохон хүчин зүйл болдог. Жишээлбэл нэг компьютер үзүүлэлтээрээ худалдан авагчид таалагдлаа гэхэд муу дизайнтай бол авах эсэх дээр эргэлзэх болно.

Компьютерийн жин, цэнэгээ барих хугацаа, дулаан ялгаруулалт, сэнсний дуу чимээ зэрэг нь ихэвчлэн түүний

хурд, хүчин чадлаас их хамаардаг. Өөрөөр хэлбэл хүчин чадал өндөртэй зөөврийн компьютер овортой байх илүү магадлалтай.

Зөөврийн компьютерийн дэлгэцийн хэмжээ хэдэн стандарттай байдаг. Тэдний “алтан дундаж” хэмжээ нь 15.6” байдаг. 15” –ээс доош 13, 14 инчийн компьютерууд нь ихэвчлэн “жижиг, авсаархан” гэсэн нэрэн доор худалдаалагддаг. Тэд дуу чимээ бага, зай нь цэнэгээ удаан барьдаг, хөнгөн, авсаархан гэсэн үзүүлэлтээрээ ялгардаг. Харин энэхүү жижиг оврын компьютерууд хурд, хүчин чадлын хувьд сул байдаг талтай.

15” –ийн зөөврийн компьютерууд нь хүчин чадлын хувьд хамгийн уян хатан байдаг. Учир нь тэд хямдхан буюу бага хүчин чадалтай хэдий ч том дэлгэцтэйгээрээ онцлог. Зарим нэг нь 18” –ийн компьютер хэмжээний хурд хүчтэй ч худалдаалагддаг.

Дээрх хэмжээнээс илүү том ямар ч зөөврийн компьютерийг “хүчин чадлын” компьютер гэж ангилдаг. Тэд сэнсний чанга дуу чимээ, их дулаан ялгаруулалт, том хэмжээ, хүнд жингээрээ алдартай. Хэдийгээр олон сул талтай ч энэхүү том зөөврийн компьютерууд бусдаасаа бүх үзүүлэлтээрээ хурдан байж чаддаг. 15”-с зөөврийн компьютерууд нь ихэвчлэн тоглоомчид, монтажлагч, график дизайнерууд гэх тусгай хэсэг хэрэглэгчдэд зориулагдсан юм. Мөн зөөврийн компьютер атлаа ширээний компьютерийг (desktop) орлох үүрэг гүйцэтгэх нь бий.

Дараах хүснэгтээс хэмжээ, хүчин чадлын хамаарлыг сонирхоно уу.

Netbooks	>15"	15"	15"<	
Хүчин Чадал	Маш бага	Бага	Бага – өндөр	Маш өндөр
Жин	Маш хөнгөн	Хөнгөн	Дунд – хүнд	Хүнд
Зай нь цэнэгээ барих	Маш удаан	Удаан	Богино – удаан	Богино
Дуу чимээ	Чимээгүй	Чимээгүй – дунд	Дунд – чанга	Чанга
Дулаан	Бүлээн	Дунд	Дунд – халуун	Халуун
Үнийн хүрээ	\$200-300	\$400 – 800	\$800 – 1,500	\$1,500<

Мэдээж дээрх хүснэгт нь ерөнхий байдлыг харуулж байгаа гэдгийг санаарай. 13, 14 инчийн, том компьютеруудтай өрсөлдөхүйц өндөр хүчин чадалтай компьютер байдаг. Мөн тэд авсаархан учир зарим хэрэглэгчид илүү сонирхдог. Товчхондоо том зөөврийн компьютер нь ихэнх тохиолдолд өндөр хүчин чадлыг илэрхийлдэг. Хүчин чадлаа дагаад хэмжээ ихсэхгүй тохиолдолд тухайн компьютерийн үнэ өсдөг.

Зөөврийн компьютер худалдан авахад бодож үзэх хамгийн чухал зүйл нь юунд хэрэглэх гэж байгаагаа тодорхойлох юм. Үүнийг зөв тодорхойлохгүй бол хамгийн үнэтэй компьютер ч хамгийн зөв сонголт биш байдаг билээ. ■

## ХУУЛЬ

# АЛТНЫ САЛБАРТ АРГАМЖАА ХЭРЭГТЭЙ ЮУ?

Б.БАЯРТОГТОХ

УИХ өнгөрсөн оны төгсгөлд Алтны ил тод байдлын тухай хуулийн төслийг авч хэлэлцсэн. Гэвч алтны салбарынхны ихэд найдлага тавьж байсан хуулийн төсөл бүдэрлээ. Гадаад валютыг нэмэгдүүлэх. Алтны далд худалдааг зогсоох. Монголбанкны алтны нөөцийг өсгөх. Эдгээр зорилтын “автор” болсон хуулийн төсөл өвдөг шороодсон нь тус салбарт хүчээ үзэж буй хэн бүхний сэтгэлийг гонсойлгов. Бараг л УИХ “ногоон гэрлээр” батална гэж тооцоолж байсан хуулийн төсөл он дамжлаа. Энэ нь зөвхөн алтны салбарт ч бус Засгийн газар, Монголбанкны хувьд тун таагүй мэдээ байв.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 2005 онд 2.5 хувь байхад манай улс 24 тонн алт олборлож байсан. Тэгвэл “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” хэрэгжиж эхэлснээс хойш алтны олборлолт жил дараалан буурчээ. Ингэснээр 2012 онд зургаан тонн хүрэхээ больж, дээрхээс дөрөв дахин буурсан байдаг. Тиймээс Засгийн газраас алтны худалдааг зохицуулах эрх зүйн орчинг сайжруулахаар “Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай” хуулийн төслийг боловсруулсан нь энэ.


Монголбанкны алтны нөөц

өнгөрсөн хугацаанд санасан хэмжээнд хүртэл тэлээгүй. Уг байдал нь валютын нөөцийг зузаатгах гэсэн төвбанкны хүсэлд тээг болсоор. Монгол Улс өнгөрсөн 20 жилийн хугацаанд нийт 130 гаруй тонн алт олборлосон байдаг. Гэвч Монголбанк хангалттай хэмжээний алт үүцэлж чадаагүй. Одоогийн байдлаар Төв банк 5.8 тонн шар металлын нөөцтэй. Энэ нь валютын ханшийн өсөлтийг аргамжих хангалттай нөөц биш гэж зарим эдийн засагч үзэж буй.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал “Нэг хэсэг Монгол-банкндаа алт тушаадаг. Тэрний эсрэг төгрөг гаргадаг байлаа. Гэтэл одоо байдал эсрэгээрээ явна. Дэлхий дээр мөнгөтэй, валюттай болдог хэд хэдэн арга байдаг. Тэр дундаа валют олдог дөрвөн урсгал нь дөрвүүлээ Монголд байна. Зарим улсад гурав байдаг. Манайд байгаа нэг том давуу тал бол алт” хэмээн тайлбарласан. Төвбанкны хувьд алтны нөөцөө зузаатгах нь валютын орлоготой болж байна гэсэн үг.

Дэлхийн орнуудын Төвбанк алт нөөцөлж, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлаа баталгаажуулдаг. Манай улс мөн адил дээрх үүргийг хүлээж буй. Алтны салбарт 128 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Зарим жилд алтны олборлолт 20 хүртэлх тонноор өссөн байдаг. Алтны олборлолт харилцан адилгүй байгаа нь хэрэгжиж буй хууль эрх

Унци алтны дундаж үнэ (ам.доллараар)



Эх сурвалж: Ашигт малтмалын газар

зүйн орчинтой холбоотой болохыг тус салбарт ажиллаж буй мэргэжлийн хүмүүс хэлдэг.

Шүүмжлэлд байнга өртөж байдаг алтны салбарт гэнэтийн ашгийн 68 хувийн татвар 2007 онд гарч байсан. Энэ хууль хэрэгжих болсноор компаниудын их хэмжээний хөрөнгө оруулалт үнэгүйдэж, алтны худалдаа далд хэлбэрт шилжсэн гэдэг. Мөн нөхөн сэргээлт хаягдах байдалд орж, олборлолт болон борлуулалт бүгд далдаар явагдаж эхэлсэн хэмээн Монголын Алт үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн Т.Ганболд хэллээ.

Үүний дараа “Урт нэртэй” хууль гарч ирснээр нөхцөл байдал “сахил хүртээд шал дордсон” болохыг

▶ тэрбээр мөн учирласан юм. Түүний хэлснээр энэ хууль нинжа буюу хууль бус алт олборлогч олноор бий болох үндэс нь болжээ. Улсын хэмжээнд 70 гаруй мянган нинжа байдаг гэсэн статистик судалгаа бий. Дээрх хууль эрх зүйн баримт бичгээс үүдэн алт, эрдэнэсийн сан арвижих үүд хаагдаж, нөөц далд хэлбэрт орсныг салбарынхан хэлж байна.

Уул уурхайн сайд Д.Ганхуяг “Алтны зах зээлийн үнэ өсөөд байхад манай улсад олборлосон алтны хэмжээ буурч байгаа. Үүний гол шалтгаан нь гэнэтийн ашгийн албан татварын хууль батлагдсанаар татвараас зайлсхийж хууль бусаар олборлосон алтны хэмжээ нэмэгдсэн. Мөн “урт нэртэй” хууль гарч түүнийг хэрэгжүүлэх зорилгоор хуульд хамрах талбайн хэмжээ нэмэгдэж 1336 тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах боломжгүй болсонтой холбоотой” гэв.

Уг салбарыг хөгжүүлэх үүднээс Алтны ил тод байдлын тухай хуулийн төслийг шинээр санаачилсан гэж Уул уурхайн яамнаас тайлбарлаж буй. Засгийн газраас зүтгүүлсэн хуулийн төсөл хэдий бүдэрсэн ч УИХ-д дахин оруулахаар зэхэж байгаа. Алтны эдийн засаг дахь урт хугацааны мөнгөний эх үүсвэр гэдэг. Н.Золжаргал “Манайд олборлосон алтыг Хятадын Төвбанк

руу биш, Монголбанкинд тушаагаад 2.5 хувийн хөнгөлөлт эдлүүлэх юм. Үүний гол учир нь нийт алтын 97.5 хувийг Монголын эдийн засагт үлдээх эдийн засгийн сонирхол. Гэтэл одоо эсрэгээрээ Монголд олборлосон алтыг 100 хувь гадагшаа гаргаад Монголын төр ердөө таван хувийн татвар авч байна” гэв.

Хуулийн төслийг баталсан тохиолдолд алт үйлдвэрлэгч компаниудад ашигтай болохыг УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ хэлж буй. Гэхдээ тус хуулийн төсөл батлагдсан тохиолдолд шар металл нь валютын цэвэр нөөц болох давуу талтай. Нөгөөтэйгүүр валютын хомсдолтой эдийн засагт алтнаас илүү сонголт үгүй болохыг Н.Золжаргал тэмдэглэсэн.

Манай улсад 1960 оноос алтны геологи хайгуулал, ашиглалт эрчимжсэн байдаг. Тухайлбал, 1974 онд Толгойтын ордыг ЗХУ-тай хамтран ашиглаж эхэлсэн гээд XX зуунд алт орлогын нэг эх үүсвэр байжээ. Тэр үед дунджаар 700-800 кг алт олборлож байсан. Тэгвэл өнгөрсөн онд манайх 7.6 тонн алт олборлосон. Алтны ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ дахь намын бүлгүүд дэмжиж байгаа ч “Оюутолгой” компанид хөнгөлөлт үзүүлэх гэсэн хуулийн төсөл хэмээн сэм хардаж буй.

УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар “УИХ дахь МАН-ын бүлэг Оюутолгойд дахин татварын хөнгөлөлтийг үзүүлэх гэж байгааг эсэргүүцэж байгаа. Учир нь Оюутолгой 1800 тонн алтны нөөцтэй. Тэгвэл хуульд зааснаар байгалийн нөөц ашигласны таван хувийг 2.5 болгож бууруулах юм бол Оюутолгойд хамгийн багаар тооцож үзэхэд гурван тэрбум ам.долларын хөнгөлөлт үзүүлэхээр болж байгаа юм. Энэ бол маш их мөнгө” хэмээн байр сууриа илэрхийлсэн. Мөн байгаль орчинд Алтны ил тод байдлын тухай хуулийн төсөл гамшиг дагуулах эрсдэлтэй болохыг УИХ-ын зарим гишүүн сануулж буй. Сөрөг хүчин сөрсөөр, олонх урагш түрсээр буй хуулийн төслийн талаарх зөрүүтэй мэдээлэл хөвөрсөөр.

“Манай улс эдийн засаг, татварын тааламжтай үед буюу 2004, 2005 онд Монголбанкинд жилд 24 тонн алт тушаадаг байсан. Хэрэв энэ хууль цуцлагдвал бүр далд хэлбэрт орно” хэмээн Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооны зүгээс мэдэгдсэн.

УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн “Нөөц ашигласны татварыг 2.5 хувь болгож бууруулбал Оюутолгойгоос орж ирэх 90 сая ам.долларын 37 сая ам.доллар нь алга болно” хэмээсэн. Хуулийн төсөл батлагдсан тохиолдолд улсын төсөвт жил бүр орох татвар, хураамжийн хэлбэрээр орох орлого 40-50 сая ам.доллараар буурах аж. Гэвч банкин дахь алтны болон валютын нөөц жилд 1.7-2.0 тэрбум ам.доллараар нэмэгдэх Эдийн засгийн хөгжлийн яамны судалгаа бий.

Хууль хэрэгжих таван жилийн хугацаанд 8.5-10.0 тэрбум ам.долларын гадаад валютын нөөцтэй болох аж. Харин Монголбанкинд алтаа худалдахгүй тохиолдолд таван хувийн роялти төлөөд явах юм. Энэ хуулийн хэрэгжих таван жилийн хугацаа дуусмагц бүх компани таван хувийн роялти төлөх ёстой. Улс төрчдийн дунд шинэ маргаан өдөөж буй тус хуулийн төслийг УИХ хэрхэх нь ирэх өдрүүдэд тодорхой болох юм. ■



## СУДАЛГАА

# С.ОЮУН САЙД ДЭЛХИЙД ДАНСЛАГДАВ

Б.БЯМБАА

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд Санжаасүрэнгийн Оюун “Дэлхийн уул уурхайн салбарын шилдэг 100 эмэгтэй” судалгаанд бичигджээ.

Тус судалгааг Их Британийн “Эмэгтэйчүүд уул уурхайд” (WIM) хэмээх төрийн бус байгууллага гаргасан байна. WIM нь 2006 онд үүсгэн байгуулагдсан юм. Одоогоор бусад улсад нийт 1200 гаруй гишүүн байгууллагатай.

Уул уурхайн салбарт бусад салбаруудтай харьцуулахад эмэгтэйчүүд хамгийн цөөн байдгийг WIM тодорхойлсон юм. Мөн 2012 оны судалгаагаар нь эмэгтэй хүн олонтой уул уурхайн компаниуд нь эмэгтэй хүн цөөнтэй компаниудтай харьцуулахад үр өгөөжтэй, ашигтай ажилладаг гэсэн дүн гарчээ. Энэхүү байгууллага нь шинэ үеийн мэргэжилтнүүдэд үлгэр дууриалал болох хүмүүс маш чухал гэсэн үүднээс тус судалгааг гаргасан байна. Үүгээрээ уул уурхайн салбар руу эмэгтэйчүүдийг татах нэг санааг ч илэрхийлсэн гэнэ.

WIM нь дэлхийн уул уурхайн салбарт ажиллаж буй шилдэг эмэгтэйчүүдийг жагсааж, дэлхийн уул уурхайн салбарт эерэг нөлөө үзүүлсэн, өөрийн орны уул уурхайн салбарын ирээдүйд жинтэй хувь нэмэр оруулсан зэрэг олон шалгуураар 500 гаруй эмэгтэй дундаас сонгон шалгаруулсан юм.

Энэхүү сонгогдсон 100 эмэгтэйд



Фотог Б.Бямба-Очир

ямар нэг шагнал урамшуулал олгохгүй аж. Харин бусад залуу эмэгтэй уурхайчдад тус салбарт ажиллах урам зориг өгөх зорилготой юм.

WIM байгууллагын дарга Amanda Van Dyke “Үлгэр дууриалал болох олон эмэгтэйгээс зөвхөн зууг нь шалгаруулахад амаргүй байсан” гэв. Мөн тэрбээр “Гэхдээ сонгосон 100 эмэгтэй хэд хэдэн шалгуураар бусдаасаа ялгарч байгаа. Тэд уул уурхайн салбарт үүрд үлдэх эерэг өөрчлөлтүүдийг хийж чадсан. Мөн тэд бусад эмэгтэйчүүдийг уг салбарт ажиллах гэж тэмүүлэхэд үлгэр дууриал нь болж чадсан” гэсэн юм.

Судалгаанд ганц монгол эмэгтэй байсан нь С.Оюун юм. Түүний тухайд “Тэрбээр дэлхийн томоохон уул уурхайн компани Rio Tinto –д ажиллаж байсан. Улмаар С.Оюун Монголын улс төрд орж, Иргэний Зориг нам байгуулж, сонгуулийн санхүүжилт, мянганы хөгжлийн зорилт, мөн авлигын эсрэг хууль тогтоомжуудын талаар эрчимтэй ажиллаж байгаа нэгэн” гэжээ.

Бусад эмэгтэйчүүдийн хувьд олонх нь уул уурхайн салбарт 20 –иос доошгүй жил ажилласан туршлагатай ажээ. Мөн энэхүү судалгаа нь удирдах албан тушаалд удаан хугацаагаар ▶

► амжилттай ажилласан, уурхайн нөхөн сэргээлтийн ажилд онцгой анхаарсан, ажиллах хүчний эрх ашиг болон олборлолт явагдаж байгаа нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалсан, бусад эмэгтэйчүүдийг тус салбарт хөл тавихад нь тус дэм болсон эмэгтэйчүүдийг багтаасан байна.

Тухайлбал, Колумба улсын хамгийн том алтны уурхайн компаний захирал Maria Consuelo Агаъо нь түүний компани олборлолт явуулж байгаа газар нутгийн иргэдийн боловсрол, аж амьдралд өндөр ач холбогдол өгдөг гэж онцолсон байна. Тэрбээр компаний зүгээс иргэдэд газар олгох, цэвэр усны худаг гаргах, мөн урлагийн тоглолт үзүүлэх зэргийг тогтмол зохион байгуулдаг байна.

Maryse Belanger нь Канадын Goldcorp Inc. –ийн Техникийн үйлчилгээний дэд захирал юм. Эрэгтэйчүүд давамгайлсан уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийг дэмжих олон ажил зохион байгуулж байсныг нь тус судалгаанд дурджээ.

Австралийн Sandra Collins тус улсад уул уурхайн инженерээр сурсан хоёр дахь эмэгтэй ба Queensland мужийн анхных юм. Тэрбээр 1985 онд эмэгтэйчүүдийг гүний уурхайд ажиллахыг хориглосон хуулиас тусгай зөвшөөрөл авч гүний уурхайн менежментийн ажлаа хийж гэрчилгээгээ гарджээ. Мөн түүний удирдсан төрийн бус байгууллагууд уурхайн ажилчдын уян хатан ажлын цаг, цалинтай жирэмсний амралт, хагас цагийн уурхайн ажил зэрэг дүрэм журмыг тухайн мужид мөрдүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн аж.

Судалгааны сонирхолтой баримт гэвэл уул уурхайн салбарын ТУЗ –ийн гишүүд нь дэлхийн бусад байгууллагуудын ТУЗ–ийнхнээс хамгийн цөөн эмэгтэйчүүдтэй нь юм байна. Гэтэл уул уурхайн компаниудын удирдах шатанд эмэгтэйчүүд харьцангуй олонтой компаниуд нь бусдаасаа санхүүгийн хувьд илүү ашигтай ажилласан байжээ. ■

## НОМЫН БУЛАН

# “ГУРВАН НАЙЗ”

“Энэхүү номыг би хайр халамж, аз жаргалаар дүүрэн хүүхэд нас бэлэглэсэн ээж Дороте Шрёдерт зориулж байна. Түүнээс би “юмханаар юм хийх” урлагийг суралцсан билээ. Тэрбээр ой мод, нугаас олсон өчүүхэн зүйлээр гайхамшигтай тоглоом хийдэг байсан юм” хэмээн “Гурван найз” номын зохиогч хатагтай Лили Шрёдер уг номын эхний хуудсанд онцолжээ. Цэцэрлэгийн хүмүүжүүлэгч мэргэжилтэй тэрбээр анх хүүхдүүдэд дүрсний тухай хичээл орох үеэрээ эл номынхоо санааг олжээ. Герман сурган хүмүүжүүлэгч эмэгтэйн номыг “Mongolian Economy” сэтгүүл “Номын булан”-даа онцлох болсон нь учиртай.


Бага насны хүүхдэд дүрсний тухай ойлголтыг өгөх энэ номын өгүүлэмж, зургийн зохиомж нь тун догь. Догь гэдэг нь бага насны балчирхан оюунд яг таарсан тун үнэмшилтэй өгүүлэмжтэй гэсэн үг. Нэг талаас энэ номыг уншсанаар эцэг, эхчүүдэд хүүхдэдээ заавал дэлгүүрээс өндөр үнэтэй тоглоом авч өгөх нь түүнийг баярлуулж, оюун ухааныг нь гарцаагүй хөгжүүлэх хэрэг үү? гэдгийг бодож үзэхэд гэмгүй юм. Нөгөө талаас номын өгүүлэмжид гарч байгаа гурван найзын амьдралын түүхийг өгүүлэхдээ эсгийгээр дүрс хайчлан дүрсэлсэн нь энгийн хийгээд бяцхан хүүхдүүдийн сэтгэхүйд наалдацтай шийдэл аж. Улаан, шар, цэнхэр өнгөтэй эсгийгээр хийсэн эгдүүтэй гурван дүрс Эки, Каро, Рунда гэсэн гурван өөр зан төрхтэй хүүхдүүдийн адал явдлыг өгүүлнэ.

Тус номыг ийм сонирхолтой зургаар дүрслэх инновацлаг санааг манай сэтгүүлч Х.Хулан маань анх санаачилсан байна. Мөн тэрбээр уг номыг англи хэлнээс монгол хэл рүү хөрвүүлсэн билээ. Харин Герман хэлнээс англи хэл рүү АНУ-ын орчуулагч Агата Хаун орчуулжээ. Агата Хулан хоёр найзууд.

Монголд анх удаа хэвлэсэн эл номыг “Номын хишиг” хэвлэлийг газраас монгол, англи хэл дээр гаргасан байна.

“Гурван найз”-ын адал явдлын зургийг Говь-Алтай аймагт эсгий урлалын багш Вивиэн Янг эсгийгээр хийжээ. Зохиолч Лили Шрёдер нь 1949 онд ХБНГУ-ын Мюньхен хотын ойролцоох тосгонд төрсөн. Тэрбээр Монтессорын нэрэмжит цэцэрлэгт хүмүүжүүлэгчээр ажилладаг. Хүүхдийн ном маш их сонирхдог. Тийм ч учраас түүний гэрийн номын сангийн дийлэнх хэсгийг хүүхдийн ном эзэлдэг байна. Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэн задлахад нэмэртэй тус номын адал явдлыг Та ч гэсэн хүүхдэдтэйгээ дуртай материалаараа урлаж үзээрэй!

Манай Хулан мөн л Лили Шрёдерийн адилаар хүүхдийн ном ихэд сонирхдог. Тэрбээр анх удаа хүүхдийн ном орчуулаагүй. 2011 онд зохиолч Фритц Мюленвегийн “Зугаатай аялал” номыг герман хэлнээс монгол хэл рүү хөрвүүлж байсан билээ. Хуландаа болон түүний хамтрагч хүүхдийн зохиол сонирхогч уран бүтээлчдэд “Mongolian Economy” сэтгүүлийн зүгээс баяр хүргэж, амжилт хүсье. ■



## ОЮУТОЛГОЙ

# ИЛ УУРХАЙГААС ДАЛД УУРХАЙД

## Б.АЛТАЙ

Таамаг төдий 2014 он морилон ирлээ. Эдийн засаг хэрхэх бол. Энэ оны эдийн засгийн өнгийг тодорхойлогчдын нэг нь “Оюутолгой”. Дэлхийд дээгүүр жагсах тус уурхайн үйл ажиллагаанаас Монгол Улсын эдийн засаг нэг хэсэгтээ л хамааралтай байх нь дамжиггүй. Өөрөөр хэлбэл, эдийн засаг өсөх бас хөгжих эсэх нь “Оюутолгой”-гоос шууд болон шууд бусаар шалтгаалах юм.

Манай улсын хувьд “Оюутолгой” ордыг түшиглэн хөгжих сонголтоо аль хэдийнэ /2009 онд/ хийсэн гэж хэлж болно. Хүлээлт тээж буй тус орд үүцээ задалж эхэлсэн 2013 он. Тэгвэл ашигтай ажиллах. Ингэснээр бүтээн байгуулалтын зардлаа нөхөх жилүүдийн эхлэл нь 2014 он болж байна.

“Оюутолгой” компанийн энэ оны төсөвт үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардал 1.3 тэрбум ам.доллар. Энэ бол оны өмнө баталсан тус компанийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн XV хурлын шийдвэр. Төсөвт суусан борлуулалтын нийт орлого нь 2.6 тэрбум ам.доллар байх юм.

Өнгөрсөн хугацаанд “Оюутолгой” 250 мянган тонн зэсийн баяжмал олборлосон. Түүнээс БНХАУ-ын Ганц модны боомтын агуулахад 70 мянган тонныг хүргэсэн. Үүнээс хайлуулах үйлдвэрүүд 20 орчим мянган тонныг татжээ.

Энэ онд “Оюутолгой” компанийн хувьд бүтээн байгуулалтаас үйлдвэрлэлд шилжих. Мөн далд уурхайн хөрөнгө оруулалт шийдэгдэх. Хөрөнгө оруулагч талуудын “урт настай” хэлэлцээр амжилттай өндөрлөх. Түүний үр дүнд “Оюутолгой” дээрх хэмжээний борлуулалт хийнэ гэсэн үг. Ингэснээр экспортод эзлэх зэсийн баяжмалын хэмжээ одоогийнхоос эрс нэмэгдэх юм.

“Оюутолгой” энэ онд нийтдээ 690 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Энэ нь “Эрдэнэт” үйлдвэрийнхээс 200 гаруй мянган тонноор илүү. Өөрөөр хэлбэл, Оюутолгойн олборлолт Эрдэнэтээс давах юм. Цаашдаа Оюутолгойн үйлдвэрлэл жигдэрч, бүтээгдэхүүний гарц ийн өсөхөөр байгаа.

Өнгөрсөн он “Оюутолгой” компанийн хувьд хэлэлцээрийн жил байсан гэж хэлж болно. Түүчлэн ил уурхайн олборлолт эхэлсэн онцлог жил. Үүнийг түүхэн хэмээн хөрөнгө оруулагч тал тэмдэглэж буй. Тэгвэл 2014 он үйлдвэрлэл нэмэгдэх. Түүний үр ашиг дээшлэх. Өгөөж хүртэх жил. Үүнээс гадна улс төрийн ээдрээ арилсан он байх юм.

Учир нь энэ он сонгуульгүй гэдгээрээ өнгөрсөн онуудаас ялгаатай. Тиймээс “Оюутолгой”-н хувьд 2014 он алдаж болохгүй алтан боломж. Ил уурхайн олборлолтоос далд уурхайн бүтээн байгуулалтад шилжих гарааны жил.

Түүчээ төслийн хүрээнд өрнөж буй ▶▶



▶ яриа хэлэлцээ цагаан сараас өмнө өндөрлөх бололтой. Хуримтлагдсан 30 гаруй асуудлаас 21-ийг нь шийджээ. Үүнээс гадна нэгдсэн ойлголцолд хүрсэн болохыг тус компанийн ТУЗ-ийн гишүүн Ч.Отгочулуу цохон тэмдэглэсэн.

Одоо үргэлжилж буй яриа хэлэлцээгээр далд уурхайг ашиглалтад оруулахад Монголын Засгийн газар ба хөрөнгө оруулагчдын хамтран ажиллах нөхцөлийг хэлэлцэж байгаа аж. Энэ оны хоёрдугаар улиралд багтаан гүний уурхайн техник эдийн засгийн үнэлгээ /

ТЭЗҮ/-г шинэчилж батлах тухай ярьж буй.

Ингэснээр ирэх зун гэхэд далд уурхайг ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Хэрэв дээрх хэлэлцээрт саад гарвал түүний уршиг далд уурхайн ашиглалтад орох хугацааг дахиад сунгах юм. ■



“Оюутолгой” энэ онд нийтдээ 690 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Энэ нь “Эрдэнэт” үйлдвэрийнхээс 200 гаруй мянган тонноор илүү.

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

# НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ



Т.ЧУЛУУН (БОНХ-ийн сайдын зөвлөх)

Одоогоор соёл иргэншлийн талаар тогтсон тодорхойлолт байхгүй аж. Системийн онолчид соёл иргэншлийг өөр хоорондоо харилцан үйлчлэлцэх нийгэм, эдийн засаг, улс төр, соёл зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдтэй цогц тогтолцоо хэмээн үздэг. Дэлхийн тогтолцоо нь хүн төрөлхтний соёл иргэншлийг, экосистем нь соёл иргэншлээ агуулдаг утгаар нь соёл иргэншил ба байгаль орчныг цогцоор нь ногоон соёл иргэншил гэж авч үздэг. Экосистем нь хүнгүйгээр оршин тогтнож чадна. Харин хүн экосистемгүйгээр, экосистемийн үйлчилгээг авахгүйгээр оршин тогтнох чадваргүй. Ногоон соёл иргэншил Соёл иргэншил–нийгэм, эдийн засаг, улс төр ба соёлын харилцан үйлчлэл бүхий цогц тогтолцоо. Дэлхийн амьдралыг тэтгэх тогтолцоо өнөө болон хойч үеийн аж амьдралын сайн сайхан байдал нь шалтгаалах Дэлхийн амьдралыг тэтгэх тогтолцоог найдвартай хамгаалж, өнөөгийн хэрэгцээгээ ханган хөгжих нийгмийн тогтолцоог ногоон соёл иргэншил гэнэ. Sustainable Development Goals for People and Planet Nature 495, 305–307 (2013)

Ногоон хөгжил бол үнэндээ тогтвортой хөгжил гэсэн үг. Өнөө үеийнхэн хэрэгцээгээ хангахдаа, ирээдүй үедээ хэрэгцээгээ хангах боломжийг өвлөн үлдээх зорилготой үе үеийн тэгш байдал нь тогтвортой хөгжлийн үндэс юм. Иймээс үр хүүхэд болон хойч үеэ ирээдүйд сайн сайхан амьдраасай хэмээх хүсэл эрмэлзэлтэй тогтвортой хөгжлийн үзэл санаа бүрэн нийцдэг. Бид 2030 онд хүртэл “Ногоон соёл иргэншил” стратеги, зорилтот хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхээр болсон. Уг төлөвлөгөөний дагуу Монгол Улс хөгжлийн хандлагаа эрс шинэчилж, тогтвортой хөгжлийн замаар замнах юм. Монгол Улс эдийн засгийн өсөлтөөр дэлхийд тэргүүлж эхэллээ. Мөн уламжлалт соёл иргэншлээ хадгалсаар мэдээллийн технологийн эрин үед шилжин орлоо. Энэ бүхэн Монгол Улсад сэргэн хөгжих алтан боломжийг нээж байна. НҮБ-ын тогтвортой хөгжлийн хурлын “Бидний хүсч буй ирээдүй” үндсэн баримт бичигт заасан гол чиглэлүүдээр Монгол Улсын Ногоон хөгжлийн стратегийг дэвшүүлсэн. Харин

Монголынхоо өвөрмөц онцлогийг тусгах үүднээс “соёл ба өв” гэсэн чиглэлийг ногоон хөгжлийн стратегид нэмж оруулсан юм.

**Уур амьсгалд зохицсон хөгжил:** Монгол Улсуур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, ногоон хөгжлийн бодлоготой уялдуулахыг гол зорилго болгож байгаа юм. Дэлхийн дунджаас бараг гурав дахин хурдацтай явж буй манай улсын дулаарал нь газар нутгийг улам хуурайшуулах үр дагавартай байна. Судлаач Мижиддорж гуайн нэрлэсэнээр уур амьсгалын өөрчлөлт нь “гэтэн ирж буй аюул” болоод байгаа. “Энэ аюул” зөвхөн малчдын амьдралд төдийгүй “уур амьсгалын дүрвэгсэд” Улаанбаатар болон бусад хотод нүүж ирснээр агаарын бохирдол, хот орчмын бэлчээрийн болон хөрсний доройтол гээд нийслэлийнхэнд ч сөрөг үр дагавартай байгаа юм. Тиймээс ногоон хөгжлийн бодлогыг хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахтай харилцан уялдуулбал Монголд болон дэлхийд аль алинд нь үр ашигтай. Мөн дасан зохицох технологи нэврүүлэхэд олон улсын санхүүжилтыг олох магадлал нэмэгдэж, хамтын ажиллагаа илүү үр дүнтэй болно. Тухайлбал, сэргээгдэх эрчим хүчээр Монголын нөхцөлд ажиллах хөргөгчийг шинээр зохион бүтээж, ялангуяа зудын нөхцөлд, малаа цөөлөөд махаа хадгалахад тус “шинэ” хөргөгчийг ашигламаар. Зудад олон мал алдахгүй. Мөн бэлчээрийн экосистем ч сайжирна. Ногоон ▶

► хөгжлийн тийм төслийг БОНХЯ нь Япон улстай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**Ногоон эдийн засаг:** Ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалт, зээлийн механизм болон ногоон ажлын байруудыг бий болгох, хувийн хэвшлийн ажилтнуудад ногоон хөгжлийн мэдлэг боловсрол олгох. Биотехнологи, мэдээллийн технологи, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх. Эрчим хүч, дэд бүтэц, хөдөө аж ахуй, барилга, хот байгуулалтын салбаруудад нөөцийн үр ашгийн 3R (Reduce, Re-use and Recycling)-ын зарчим буюу хаягдлыг бууруулах. Мөн эргүүлэн ашиглах, дахин боловсруулж шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх зарчмыг хэрэгжүүлэх зэрэг тулгамдсан асуудал олон бий. Үндэсний байгаль, соёлын өв газруудыг бий болгож, ногоон соёл иргэншлийн хөгжлийн бүс болгон хөгжүүлэе. Тухайлбал, Алтайн нуруу, Их нууруудын хотгорыг нүүдлийн соёл иргэншлийн өлгий-үндэсний байгаль-соёлын хосолмол өв газар, Бурхан Халдун болон Онон-Балжийн сав газрыг тулгар төрийн үндэсний өв газар, цагаан зээр бүхий хялганат хээрийн байгалийн үндэсний өв, Их говийн байгалын үндэсний өв, Хөвсгөл нуурын орчмын нутгийг цаатан соёл иргэншлийн өв газар болгон “тамгалж”, ногоон технологиор баяжуулан хөгжүүлснээр Монгол орон ногоон байгаль-соёл-түүхийн өвөрмөц брэнд орон болно. Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийн өв Монголд л үлдээд байна.

Тэгш байдал ба ядуурал: Эрүүл орчин нь аз жаргалтай амьдралын үндэс бөгөөд үүнийг дундаж наслалтын уртсалтаар хэмжиж болох юм. Хөгжсөн орнуудыг өөр хооронд нь харьцуулан судлахад, Япон, Швед, Норвеги зэрэг орлогын тэгш бус байдал багатай орнуудад эрүүл мэнд болон нийгмийн бусад үзүүлэлтүүд Америк, Португал, Англи зэрэг орлогын тэгш бус байдал өндөр орнуудаас илүү сайн гарчээ. Англи Улсын Ерөнхий Сайд Давид Камерон 2009 оны сүүлээр хэлсэн үгэндээ “Хөгжсөн улсуудыг харьцуулан судлахад баян ядуугийн ялгаа ихтэй

улсууд амьдралын чанарын ихэнх үзүүлэлтээр хамгийн муу нь байна” гэж онцлон хэлжээ. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээнээс бус тус улсад баян ядуугийн ялгаа ямар байхаас хүн амын дундаж наслалт, эрүүл мэнд, гэмт хэргийн түвшин, бичиг үсгийн тайлагдал илүү их хамаарч байна” хэмээжээ. Одоо Монголын хүн амын дундаж наслалт 69 (эмэгтэй 73, эрэгтэй 65) байгааг 2020 онд 72, 2020 онд 75 болгох саналыг дэвшүүлж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд ногоон ажлын байранд 70 нас хүртлээ ажиллах, эрэгтэйчүүдийн наслалтыг уртасгах зорилгот хөтөлбөр боловсруулж бодлогоор хангаж ажиллах зэрэг тууштай цогц арга хэмжээ авах шаардлагатай юм. Монгол Улс 2030 онд ядуурлыг бүрэн арилган, нийгмийн тэгш байдлыг хангаж амьдрах боломжтой гэж үзэн, хөдөлмөрийн чадвартай Монгол хүн бүрийг их бүтээн байгуулалтад оролцуулж, ажил хийсэн бүхэнд чинээлэг амьдрах нөхцөлийг бүрдүүлбэл бид зорилгоо биелүүлэх бүрэн боломжтой.

### **“Шинэчлэл”-ийн шинжлэх ухааны үндэслэл**

Монгол Улс ногоон соёл иргэншлийг байгуулах нь шилжилт ч биш, шинэтгэл ч бус. Харин жинхэнэ утгаар нь шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсын хөгжлийн шинэчлэлийн үндэслэлийг орчин үед улам бүр өргөнөөр хэрэглэх болсон сэргэн хөгжихүйн (resilience) онолоор тайлбарлая. Resilience гэсэн үгийг уян хатан чанар гэж материалын хувьд орчуулдаг боловч тогтолцооны онолын хувьд тохирсон орчуулга байхгүй юм. Аливаа тогтолцооны нөхөн сэргэх болон шинэчлэгдэн хөгжих гэсэн утгаар “сэргэн хөгжихүй” хэмээн нэрлэх саналыг оруулж байна. Өсөлт (r); Хөгжил (K); Уналт ( ); Шинэчлэл ( ) Ой санамж (remember), сүйрэл (revolt) гадны үйлчилгээ байсан ч үйл ажиллагаагаа хэвийн хадгалах чадавхитай тогтолцоо байдаг. Тухайлбал, хүн эрүүл байхын тулд дархлаатай байх хэрэгтэй бөгөөд дархлаа бол нөхөн сэргэх

чадамжийг харуулдаг. Экосистемийн тогтвортой менежментийн амин сүнс бол аяндаа нөхөн сэргэх чадавхи буюу “дархлаа”-г нь алдагдуулахгүй байх явдал юм. Нөхөн сэргэх чадавхиа алдсан экосистем цөлждөг. Сүйрлийн эсрэг хариу үйлдэл хийж шинэчлэгдэх чадамжтай тогтолцоо ч бий. Аливаа халдлагыг даван туулах, өртвөл нөхөн сэргэх, сүйрлийн эсрэг хариу үйлдэл хийж шинэчлэгдэх чадавхитай тогтолцоог дасан зохицох тогтолцоо (adaptive system) гэнэ. Материалын уян хатан байдал, аливаа тогтолцооны аяндаа нөхөн сэргэхүй буюу “дархлаа”, дасан зохицох тогтолцооны шинэчлэгдэх чадавхыг цогцоор нь сэргэн хөгжихүй (resilience) гэж тодорхойллоо. Аливаа түвэгтэй тогтолцоо нь өсөх, ханах, гэнэтийн үйлчлэлд өртсөний дараа нөхөн сэргэх эсвэл шинэчлэгдэх зэрэг мөнхийн динамиктай байдаг. Жижиг тогтолцооны сүйрэл том тогтолцоогоо сүйрэл рүү хөтлөх ч тохиолдол гарч болдгийн олон жишээг бид дэлхийн олон үйл явдлуудаас хардаг. Аливаа төвэгтэй тогтолцоо шинэчлэгдэхдээ өөрөө дотор нь агуулагддаг том тогтолцооныхоо ой санамжид ►►



► тулгуурладаг. Энэ нь дэлхийн суурин болон нүүдлийн соёл иргэншлийн баялаг өвд суурилж шинэчлэлийг хийнэ гэсэн үг юм. Нүүдлийн соёл иргэншил нь сэргээгдэх эрчим хүчинд суурилсан. Бага материал ашиглах, дахин ашиглах болон хаягдалгүй бүтэн эргүүлэн ашиглах гэсэн (3R) ногоон хөгжлийн үндсэн зарчимд тулгуурласан байдаг. Мөн эрс тэс уур амьсгал, дөрвөн улирал, ган зудад дасан зохицсон тогтвортой тогтолцоо билээ. Нүүдлийн соёл иргэншил дээрээ тулгуурлан, орчин үеийн боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг хурдасгах механизм болгон бид монгол төрхтэй ногоон соёл иргэншлийг байгуулах санаа юм.

## Монголын тогтвортой хөгжлийн төлөв ба түүний хэмжүүр

Өнгөрсөн 20 жилийн хөгжлийн үр дүнг тогтвортой хөгжлийн тулгын гурван чулуу болох эдийн засаг, нийгэм, байгаль орчин хэмээх гурван тэнхлэгийн дагуу найман хувилбараар авч үзвэл хөгжлийн

хамгийн муу хувилбар руу тогтворгүй хөгжлийн замаар чиглэж явна. Эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд тэргүүлж эхэлсэн боловч олон хэлбэршилгүй буюу дан ганц уул уурхайн орлогоор өссөн. Иймээс эдийн засаг ч тогтворгүй (2012 онд дэлхийн өрсөлдөх чадварын индексээр 142 орноос 96, 2013 онд 144 орноос 93-р байранд тус тус яваа), ядуурлын түвшин өндөр хэвээр (Мянган хөгжлийн зорилтуудаас 2015-д ядуурлыг хоёр дахин бууруулах гэсэн зорилт хэрэгжих магадлал хамгийн бага байгаа), хүний хөгжил, ялангуяа дундаж наслалт, боловсролоор дорвитой ахиц гарахгүй хэвээр (2011 онд хүний хөгжлийн индексээр 187 орноос 110-д, 2012 онд хүний хөгжлийн индексээр 187 орноос 108-д тус тус яваа) байгаа. Түүнчлэн Улаанбаатар хот агаарын бохирдлоор дэлхийд тэргүүлж, усны бохирдол, газрын доройтол хэтэрсэн тул байгаль орчин нь ч тогтворгүй болжээ. НҮБ хүний хөгжлийн индексээр улс орнуудыг эрэмбэлсээр 21 жил боллоо. Энэхүү хүний хөгжлийн индекс байгаль орчны үзүүлэлтийг нэмж тооцон, хүний тогтвортой хөгжлийн индекс бодох саналыг миний бие дэвшүүлсэн юм (Чулуун, Nature, 2011). Агаар мандал дахь хүлэмжийн хий сүүлийн сая шахам жилийн түүхэнд байгаагүй хэмжээнд хүрснээр дэлхий өнгөрсөн зуунд 0.7°C-ээр (Монгол 20°C-ээр) дулаараад байгаа нь хүн төрөлтний хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Нэг хүнд ноогдох нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт бага байх тусам байгаль орчны индекс өндөр байх санал дэвшүүлсэн. Иймээс хүний тогтвортой хөгжлийн индекс гэдэг нь НҮБ-ын хүний хөгжлийн индексийн нийгэм-эдийн засгийн 3 үзүүлэлт дээр хүний нүүрстөрөгчийн үл мөрийг нэмж тооцсон индекс болдог. Дэлхийн улс орнуудыг хүний тогтвортой хөгжлийн индекс-2011-ээр эрэмбэлэхэд: Хүлэмжийн хий ихээр ялгаруулагч АНУ, Канад, Австрали зэрэг орнууд хүний хөгжлийн индексээр эхний зургаан байрнаас 20 шахам байраар ухарч, Швед, Швейцари зэрэг орнууд Норвегийн дараа 2-3-р байранд

дэвшжээ. Тэгвэл Монгол Улсын нэг хүнд ноогдох нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт дэлхийн дундаж орчим тул хүний тогтвортой хөгжлийн эрэмбэ өөрчлөгдөхгүй байна. Монгол Улс нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэмжих индексийн саналын хамт дэвшүүлье. Ийм хөгжлийн дэвшлийг хэмжихийн тулд тогтвортой хөгжлийн индекс буюу хэмжүүрүүдийг 2014 он гэхэд боловсруулсан байх зөвлөмжийг НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргад өгчээ (United Nations Secretary-General's High-level Panel on Global Sustainability, 2012, Resilient People, Resilient Planet: A future worth choosing. New York: United Nations).

Монгол Улс баялгаа болон орлогоо хэрхэн оновчтой тэгш хүртээн, ногоон хөгжлийн замаар хэрхэн хөгжиж байгааг энэ индексээр хэмжиж болно. Мөн бусдын туршлагаас суралцах боломжтой. Швед улсын иргэд “Лагум” буюу “хэт их ч биш, хэт бага ч биш” гэсэн соёлыг нэвтрүүлсэн байна. Норвеги улс ус, Дани улс салхи, Герман улс нарны сэргээгдэх эрчим хүч ашиглалтаар дэлхийд тус тус тэргүүлж байгаа нь эдний улсын бас нэгэн онцлог гэлтэй. Япон улсын өөрт тохиолдсон байгалийн гамшгаа даван туулж, сэргээгдэх эрчим хүчийг илүү хөгжүүлэх зорилт тавьсан байдал, Герман улсын санхүүгийн хямралд хамгийн бага өртөж байгаа зэрэг нь бас нэгийг өгүүлнэ. Өмнөд хөрш Хятад улсын эдийн засгаа өндөр өсгөхдөө хүн амын 40 хувийг ядуурлаас гаргаж, “1000 авъяастан” хөтөлбөрөөр аль 1990-ээд оноос баруунд үр дүнтэй ажиллаж байгаа мэргэжилтнүүдээ бодлогоор эх орондоо урьсан. Тэднээ орон байраар ханган, авч байсан цалинг нь өгч, ажиллах нөхцөлийг нь ханган ажиллуулж ирснийг энэ дашрамд хэлье. Мөн манай улсын нэгэн адил эдийн засаг, нийгэм, байгаль орчин, улс төр болон соёлын гэсэн таван бүрэлдэхүүн эко-соёл иргэншил байгуулах үзэл баримтлалыг дэвшүүлсэн байна. 2015 оноос хойш дэвшүүлэх ёстой Тогтвортой хөгжлийн зорилгуудыг тодорхойлох гэж өргөнөөр хэлэлцэж байгаа энэ үед Бутан улсын “аз жаргалын индекс”-ийг ч сонирхож болж байгаа юм. ■





# Сар шинийн тэнд дэвшурье...

## Мэдээллийн нэгдсэн сан гэж юу вэ?

- \* Logo3s.mn
- \* Reclams.mn
- \* Mobile web
- \* Application Reclams /App store, Playstore/
- \* Реклам мэдээллийн сан
- \* Media сурталчилгаа




## Эрж хайсан зүйлээ **RECLAMS**

application - ээс

## **TOUCHSCREEN TV** Медиа сурталчилгаа

- 1.ВИДЕО РЕКЛАМ
- 2.ФОТО ТАНИЛЦУУЛГА
- 3.ТЕХТ ЗАР /УРСДАГ/

## **LOGO3S.MN**



## **RECLAMS.MN** **MOBILE WEB**



Харилцах утас: 7010-0156, 9111-6586



Их харанза компанийн захиалгаар  
Турк улсад үйлдвэрлэсэн "Илч газ"  
"Top газ" компаний борлуулалтын  
6-н үзвээс худалдан аваарай.



ИЛЧ БРЭНД

- ✓ *Аялал зугаалга амралт зуслан ахуйн бүх хэрэгцээнд*
- ✓ *Хэрэглэхэд хялбар аюулгүй абсаархан*
- ✓ *Хүйтэний улирлын хамгийн найдвартай түслэгч*
- ✓ *Дахин дахин цэнэглэж ашиглах зориулалттай*
- ✓ *5 литрийн багтаамжтай*



Газны үнэ 62'500₮  
хошуу 15'000₮  
дахин цэнэглэлт  
5500₮

18-20цаг тасралтгүй  
асах  
хүчин чадалтай.



Газын нэмэлт  
хошуу  
2 метр

Харилцах утас: 9666-7068, 9111-6586